Хавсралт 1

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

## (2020 оны жилийн эцсийн байдлаар тайлагнав)

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

2021-01-10 Улаанбаатар хот

| Шийд-вэрийн д/д | Заал-тын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, заалт, агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удааширч буй шалтгаан |
|---|---|---|---|---|---|
| **Нэг. Монгол Улсын хууль** | | | | | |
| 1 | 1 | **Хууль тогтоомжийн тухай /Шинэчилсэн найруулга/**<br>2015-05-29, Дугаар 2017.01.01<br>49.1. Улсын Их Хурал, Засгийн газар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтолцоог бүрдүүлж, холбогдох бүтцийн нэгжийг ажиллуулна. | **ТӨБЗГ – ХЭЗХ**<br>Засгийн газрын 2019 оны 438 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүргээс худалдан авах ажиллагааны чиг үүргийг салгаж, Төрийн худалдан авах ажиллагааны газар байгуулахаар шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотойгоор байгууллагын зохион байгуулалтын бүтэд өөрчлөлт орж, Ерөнхий сайдын 2020 оны 06 дугаар захирамжаар 3 хэлтэс, 2 албатай, нийт “31” орон тоотой байхаар баталсан. Уг бүтцийн өөрчлөлтөөр Хууль, эрх зүйн албыг байгуулснаар байгууллагаас гарах аливаа шийдвэр хууль тогтоомжид нийцсэн, эрх зүйн үндэслэл бүхий байх, түүний хэрэгжилтэд байнгын хяналт тавих боломж бий болсон. Улмаар Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолоор Төрийн өмчийн бодого, зохицуулалтын газрын орон тоо нэмэгдэн “55” болж, Ерөнхий сайдын 2020 оны 79 дүгээр захирамжаар бүтцэд дахин өөрчлөлт орсон бөгөөд Хууль, эрх зүйн албаны орон тоог нэмэгдүүлж, Хууль, эрх зүйн хэлтэс болгон өргөжүүлэх, чадавхийг сайжруулах арга хэмжээ авав. Түүнчлэн, Захиргаа, удирдлагын нэгжид хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан чиг үүрэг бүхий албан тушаалыг шинээр бий болгоод байна. Ингэснээр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоо бүрдсэн үр дүнтэй байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хянал-таас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | 2 | **Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/**<br>2020-05-07, Дугаар 2020.07.01<br>21.5. Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ. | **ТӨБЗГ – ХЭЗХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр анхааран ажиллаж, Засгийн газар, Ерөнхий сайдын шийдвэрээр бүтцийн өөрчлөлт хийх хүрээнд зохион байгуулалтын бүтцийн холбогдох нэгжид хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын орон тоог шинээр бий болгоод байна. Ингэснээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийг хангах, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг мөрдөн ажиллах зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлээд байна.<br>Тус байгууллага хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтыг дээр дурдсан журамд заасан хугацаа, хуваарийн дагуу Засгийн газар болон холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хянал-таас хасах саналтай. |
| | | **МУ-ын хууль: 2 хуулийн 2 заалт:** | **100% - 2 заалт. Хэрэгжилтийн хувь – 100%.** | | **Хасах санал: 2** |
| **Хоёр. УИХ-ын тогтоол** | | | | | |
| 3 | 3 | **Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай**<br>2014-06-05, № 41<br>1.Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан компанид төрийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбогдсон журмыг энэ хуульд нийцүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т, Санхүүгийн зохицуулах хорооноос өмнө баталсан холбогдох журам, заавартзохих өөрчлөлт оруулахыг Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ыг батлан мөрдөж байна. Журмын 1.3.-т “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг төр тухайн хуулийн этгээдийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх гишүүнээр томилсон этгээдээр дамжуулан хэрэгжүүлнэ” гэж заасан. Засгийн газрын 2017 оны 123 дугаар тогтоол, Засгийн газрын 2018 оны 245, 335 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 47, 175, 234, 237 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байна.<br>Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн нийтийн өмчийн тухай хуулийн төсөл, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоот компанийн тухай хуулийн төслийг тус тус хэлэлцүүлэхээр тогтсон бөгөөд хуулийн төслүүд | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хянал-таас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | батлагдсаны дараа дээрх журамд өөрчлөлт орох зайлшгүй шаардлага үүсч байгаа болно. | | |
| 4 | 4 | **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай**<br>2016-11-03, № 51<br>2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Авлигатай тэмцэх газар /Х.Энхжаргал/-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан ТӨБЗГ-ын дангаар болон хамтран хэрэгжүүлэх 4 зорилтын хүрээний 17 арга хэмжээг хяналтад аван хэрэгжилтийг зохион байгуулан ажиллав. Эдгээр арга хэмжээний 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн боловсруулж, ТӨБЗГ-ын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А-1/171 дүгээр албан бичгээр АТГ-т хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2019 оны жилийн эцсийн дүнгээр дунджаар 88.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан. Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр тайлагнан ажиллаж хэвшсэн бөгөөд 2020 оны тайланг гарган хуулийн хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлэхээр ажиллаж байна.<br>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан тус байгууллагын хариуцан зохион байгуулах, хэрэгжүүлэх, төсөв, санхүүжилт шаардагдах ажил, арга хэмжээний зардлыг тооцон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны төсвийн төслийн саналд тусгаж, Төсвийн ерөнхийлөн захирагч болон Сангийн яаманд жил бүр хүргүүлж байгаа боловч 2020, 2021 оны төсөвт тусгагдаагүй болно. Тухайлбал, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах төсвийн төслийн саналд нийт 11 арга хэмжээнд 21.9 сая төгрөгийн төсвийн санхүүжилт шаардлагатай байгааг тооцож саналаа тусгуулах арга хэмжээг аван холбогдох эрх зүйн акт, үндэслэл болох баримт материал, шаардлагатай төсвийн төслийн саналын тухай танилцуулга зэргийг бэлтгэн холбогдох байгууллагад хүргүүлсэн. Улсын төсөвт санал тусгаган батлагдах асуудал тус байгууллагаас шууд хамаарахгүй байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжиж тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай. |
| 5 | 5 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-11-17, № 69<br>4/1.Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогыг нэмэгдүүлэх; (4/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>2016 онд төрийн өмчийн ногдол ашгийн 4.3 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.<br>2017 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээг 2016 оны цэвэр ашгаас 15-30 хувиар тооцож, нийт 13.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | 2017 оны жилийн эцсийн тайлангаар хяналтаас хасч байсан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | компанийн менежментийг сайжруулах чиглэлээр) | газрын 2017 оны 117 дугаар тогтоолоор баталсан. 2017 оны жилийн эцсийн байдлаар ногдол ашгийн 12.5 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 3 дахин, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилтот түвшинтэй харьцуулахад 1.6 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байсан.<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 82 хуулийн этгээд 2018 онд 42.2 тэрбум төрийн өмчийн ногдол ашиг төвлөрүүлсэн нь 2017 оны мөн үетэй харьцуулахад ногдол ашиг 3.34 дахин нэмэгдсэн (”Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөл хэрэгжүүлдэг 11 компанийн дүн ороогүй болно).<br>2019 оны жилийн эцсийн байдлаар 43 хуулийн этгээдээс төрийн өмчийн ногдол ашгийн 155.4 тэрбум төгрөгийн орлогыг Улсын төсөвт төвлөрүүлсэн. Үүнд: “Ирээдүйн өв сан”-д ашигт малтмал олборлолтын лиценз бүхий 2 хуулийн этгээд (“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ)-ээс 151.5 тэрбум төгрөгийн, 2018 онд ашигтай ажилласан төрийн өмчит бусад 41 хуулийн этгээдээс улсын төсөвт 4.2 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашгийн орлого төвлөрүүлсэн байна.<br>Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд ТӨБЗГ-аас хариуцан нийт 174.2 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөгдсөнөөс 173.0 тэрбум төгрөгийн орлого нь төрийн өмчийн ногдол ашиг юм. Түүний 155.0 тэрбум төгрөг нь уул уурхайн олборлолтын лиценз бүхий төрийн өмчит хуулийн этгээдээс “Ирээдүйн өв сан”-д төвлөрүүлэх төрийн өмчийн ногдол ашгийн, 18.0 тэрбум төгрөг нь бусад төрийн өмчит хуулийн этгээдээс улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчийн ногдол ашгийн орлого болно. 2020 оны жилийн эцсийн дүнгээр төрийн өмчийн ногдол ашгийн 170.5 тэрбум төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлж, төлөвлөгөө 98.6 хувьтай хэрэгжсэн байна.<br>Дээрх үр дүнгээс дүгнэхэд улсын төсөвт төвлөрүүлсэн төрийн өмчийн ногдол ашгийн орлого жил бүр өссөн бөгөөд 2016 онд 4.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж байсантай харьцуулахад 2020 онд 170.5 тэрбум төгрөг болж, 39.6 дахин өссөн байна. | | Цаашид хяналтаас хасах саналтай. |
| | 6 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-11-17, № 69<br>4/2.2015 оны жилийн эцсийн санхүүгийн | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжүүд нийт өглөг 2015 онд 10,769.4 тэрбум төгрөг байсан бол 2017 оны гүйцэтгэлээр 9,501.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.7 хувь буюу 1,268.0 тэрбум төгрөгөөр буурсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | 2017 оны жилийн эцсийн тайлангаар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тайлангаар баталгаажсан 10.8 их наяд төгрөгийн өглөгийг бууруулах; (4/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн менежментийг сайжруулах чиглэлээр) | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2016 оны өр төлбөрийн дүнд Монгол Улсын Хөгжлийн банк, Төрийн банкны өр төлбөрийн нийт дүн 5.8 их наяд төгрөг орсон бөгөөд энэ нь нийт өр төлбөрийн 61.1 хувь болж байна. Үүнд дээрх банкны эх үүсвэрийг бүрдүүлэхэд үүссэн өр, үнэт цаас, бондын өр зэрэг багтсан байна. Тухайлбал, Хөгжлийн банкны өр төлбөрт Самурай бондын өр, бусад эх үүсвэрээс авсан өр төлбөр багтсан. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь үйлдвэрлэлийн техник технологи шинэчлэх чиглэлээр 1,447.4 сая төгрөгийн урт хугацаатай зээл авсан дүнтэй байв.<br><br>2019 оны жилийн эцсийн байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжүүдийн нийт өглөг 4,154.0 тэрбум төгрөг, 2020 оны жилийн эцсийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 3,883.2 тэрбум төгрөг болж буурсан үзүүлэлттэй байна. | | хяналтаас хасч байсан.<br><br>Цаашид хяналтаас хасах саналтай. |
| | 7 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2016-11-17, № 69<br><br>4/3.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн зардлыг багасгах, тэдгээрт ажиллагсдын тоог бууруулан 2012 оны түвшинд хүргэх; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>ТӨБЗГ-аас 2016 оны 12 дугаар сард төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн урсгал зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэх арга хэмжээг авч, зарцуулагдаагүй цалин хөлс, урамшуулал, томилолт, тавилга, эд хогшил, эхлээгүй ажил, үйлчилгээний зардлыг хэмнэх, төрийн өмчийн ногдол ашгийг улсын төсөвт бүрэн төвлөрүүлэх, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн удирдлага, менежментийг хэрэгжүүлж ажилласан. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ, түүний дэд хороод, дотоод аудитын тайлан, төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын тайланг дараа оны эхний 2 сард хэлэлцэн дүгнэж, гүйцэтгэх удирдлагын гэрээг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэж байна.<br><br>Тухайн компани ашиггүй ажилласан, их хэмжээний өр зээлтэй тохиолдолд ТУЗ-ийн гишүүд, хараат бус гишүүдийг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж үзэн чөлөөлж, холбогдох хууль журмын дагуу шинээр сонгон шалгаруулж томилох чиглэл баримтлав.<br><br>ТӨБЗГ-ын 2017 оны 90 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг 2019 оны 260 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, мөрдүүлж байна. Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан контрактад эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагаа, улсын төсөвт төвлөрүүлсэн ногдол ашгийн | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | 2017 оны жилийн эцсийн тайлангаар хяналтаас хасч байсан.<br><br>Цаашид хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | орлогын төлөвлөгөөний биелэлт, өр, авлага, зардлын хэмнэлт гаргасан байдлыг үндсэн үзүүлэлт болгон тусган биелэлтийг дүгнэж байгаа болно.<br><br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг сайжруулах, үйлдвэрлэл, санхүүгийн үр өгөөжийг өмнөх оноос дээшлүүлэх, өртөг зардлыг бууруулж, үргүй зардлыг багасган хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажилласны үр дүнд судалгаанд хамрагдсан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 93 хуулийн этгээд 2019 оны жилийн эцсийн байдлаар (2020 онд хийгдсэн аудитаар баталгаажсан дүнгээр) 32 их наяд 426 тэрбум төгрөгийн хөрөнгө эзэмшиж, 43990 гаруй ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж, 9 их наяд 693 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 1 их наяд 594 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь 2018 онтой харьцуулахад орлого 17.4 хувь буюу 1 их наяд 483 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 23.5 хувиар буюу 303.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд 2020 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 7,363.3 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 6,617.1 тэрбум төгрөгийн зардал гарган, 688.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай гарч байна.<br><br>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ажлын цар хүрээ нэмэгдсэн, ажил, үйлчилгээний нэр төрөл олширсон нөхцөл байдалтай холбоотойгоор ажиллах хүчний тоог 2012 оны түвшинд хүргэн бууруулах боломжгүй. | | |
| | 8 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2016-11-17, № 69<br><br>4/4.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл голлон ордог зарчимд шилжих; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх этгээдийг томилохдоо “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.1, 2.2, 2.3-д заасны дагуу холбогдох салбарын яамдуудаас санал авч, болзол, шалгуур хангасан этгээдүүдийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор томилон ажиллуулж ирсэн байна.<br><br>2016 онд Төлөөлөн удирдах зөвлөлтэй нийт 51 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх давхардсан тоогоор 450 гишүүдийг холбогдох салбарын асуудал эрхэлсэн яамдаас санал авсны үндсэн дээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн томилж байсан. Тухайн үед эдгээр 51 компаниас компанийн дүрмээр хараат бус гишүүдтэй 48 компанид | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | 2016 оны жилийн эцсийн тайлангаар хяналтаас хасч байсан.<br><br>Цаашид хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 143 хараат бус гишүүн ажилласан бол Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй нийт гишүүдийн 133 нь салбар яамдаас, 6 нь орон нутгаас, 51 нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас санал болгосны үндсэн дээр томилогдон ажиллаж байв.<br><br>2020 оны жилийн эцсийн байдлаар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 51 компанийн 39 төлөөлөн удирдах зөвлөлд нийт 347 хүн гишүүнээр ажиллаж байгаагаас 111 нь хараат бус гишүүнээр, 236 гишүүн нь төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэн ажилласан. ТУЗ-ийн 70 гаруй гишүүн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас, 166 орчим нь бусад төрийн захиргааны байгууллагаас томилогдсон албан хаагчид төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>Дээрх үзүүлэлтээс дүгнэхэд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл хэрэгжүүлж буй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудад тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл голлон ажиллаж байгаа болно. Тухайн Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн 50-аас дээш хувийг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл эзэлж байна. Энэхүү зарчим нь Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам, “Эрдэнэс монгол” ХХК-иас хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж буй компаниудад хэрэгжихгүй байна. | | |
| | 9 | **Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2016-11-17, №69<br><br>4/5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, удирдлагын цалин, урамшууллыг оновчтой тогтоох. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 41 дүгээр тэмдэглэлд нэг сарын 5.0-10.0 сая төгрөгийн цалин хөлстэй этгээдийн цалингийн хэмжээг 30 хувиар бууруулах гэж заасны дагуу 2016 онд энэ шатлалд хамрагдах цалинтай 13 хуулийн этгээдийн удирдлагын цалинг бууруулах үүрэг даалгаврыг өгч, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, удирдлагын цалин, урамшууллыг нэмэгдүүлэхгүй байх чиглэл баримтлан ажиллаж ирсэн.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2019 онд төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн удирдлагын цалин хөлс, урамшууллын тогтолцоог шинэчлэн мөрдүүлэх арга хэмжээ аван ажиллав. Энэ хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагын цалин хөлс, урамшууллыг эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний биелэлт, | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | 2017 оны жилийн эцсийн тайлангаар хяналтаас хасч байсан.<br><br>Цаашид хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ашигт ажиллагаа, улсын төсөвт төвлөрүүлсэн ногдол ашигт тулгуурлан тооцох аргачлалыг ТӨБЗГ-ын 2019 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 3 дугаар хавсралтад тодорхой зааж, уг журмыг мөрдүүлэх арга хэмжээ авсан. ТӨБЗГ-аас ТӨҮГ-ын захиралтай байгуулах, төрийн өмчит компанийн ТУЗ-өөс компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактад цалинг уг аргачлалын дагуу тооцон мөрдүүлж байна. | | |
| 6 | 10 | **Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай**<br>2019-09-13, №74<br>1.Монгол Улсын Их Хурлын 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 23 дугаар тогтоол болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн Н05/05 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газруудад тогтоосон онцгой дэглэмийн хугацааг 6 сараар сунгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Засгийн газрын 2019 оны 91 дүгээр тогтоолоор онцгой дэглэм тогтоосон байдлыг УИХ-ын 2019 оны 74 тогтоол, Засгийн газрын 2020 оны 127 дугаар тогтоолоор 2 удаа сунгасан.<br>“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газарт онцгой дэглэм тогтоосон хугацааны үйл ажиллагааны үр дүнгийн талаар болон онцгой дэглэмийн хугацааг дуусгавар болгох талаар санал боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв. Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 56 дугаар тэмдэглэлээр шийдвэрлүүлсэн.<br>“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газруудад тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд үйлдвэрлэлийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангаж, ажлын хариуцлага, сахилга, дэг журам сайжруулж, үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, эдийн засгийн зорилтуудыг ханган биелүүлснийг саашаан тэмдэглэсэн.<br>Засгийн газрын 2020 оны 56 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК (хуучин нэрээр)-ийн 49 хувийн энгийн хувьцааг худалдан авах талтай хэлцэл хийн, санал боловсруулж танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн саналыг хэлэлцэн шийдвэрлэх хүртэл онцгой дэглэмийн үед авч хэрэгжүүлж байсан ажлыг үргэлжлүүлэн үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг ердийн горимоор ажиллуулах арга хэмжээ аваад байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Онцгой дэглэмийг дуусгавар болгох, түүнтэй холбоотой Засгийн газрын 2020 оны 127 дугаар тогтоол, 56 дугаар тэмдэглэл гарсан тул цаашид хяналтаас хасах саналтай байна. |
| | 11 | **Онцгой дэглэмийн хугацааг сунгах тухай**<br>2019-09-13, №74<br>2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Засгийн газрын 2019 оны 91 дүгээр тогтоолоор онцгой дэглэм тогтоосон байдлыг УИХ-ын 2019 оны 74 тогтоол, Засгийн газрын | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Онцгой дэглэмийг дуусгавар болгох, түүнтэй |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/, тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т тус тус үүрэг болгосугай. | 2020 оны 127 дугаар тогтоолоор 2 удаа сунгасан.<br>“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газарт онцгой дэглэм тогтоосон хугацааны үйл ажиллагааны үр дүнгийн талаар болон онцгой дэглэмийн хугацааг дуусгавар болгох талаар санал боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв. Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 56 дугаар тэмдэглэлээр шийдвэрлүүлсэн.<br>“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газруудад тогтоосон онцгой дэглэмийн хугацаанд үйлдвэрлэлийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангаж, ажлын хариуцлага, сахилга, дэг журам сайжруулж, үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, эдийн засгийн зорилтуудыг ханган биелүүлснийг саашаан тэмдэглэсэн.<br>Засгийн газрын 2020 оны 56 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК (хуучин нэрээр)-ийн 49 хувийн энгийн хувьцааг худалдан авах талтай хэлцэл хийн, санал боловсруулж танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн саналыг хэлэлцэн шийдвэрлэх хүртэл онцгой дэглэмийн үед авч хэрэгжүүлж байсан ажлыг үргэлжлүүлэн үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг ердийн горимоор ажиллуулах арга хэмжээ аваад байна. | | холбоотой Засгийн газрын 2020 оны 127 дугаар тогтоол, 56 дугаар тэмдэглэл гарсан тул цаашид хяналтаас хасах саналтай байна. |
| 7 | 12 | **Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний тухай**<br>2020-01-10, №04<br>1.1/. Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:<br>1/төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах замаар орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах, шаардлагатай тохиолдолд “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг судалж, саналаа холбогдох хууль | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлага, менежментийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт харьяалан хариуцдаггүй тул энэ тогтоолын хэрэгжилт шууд хамаарахгүй байна. | “Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй” – ХБ. | Хамаарал-гүй тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тогтоомжийн өөрчлөлтийн хамт Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | | | |
| 8 | 13 | **Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай**<br>2020-12-04, № 39<br>1.5/. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг “Эрдэнэт” ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 677 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө баталсан.<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилт болох 50.0 тэрбум төгрөг төлөвлөгдсөн болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| | | **УИХ-ын тогтоол: 6 тогтоолын 11 заалт.** | **100% - 10 заалт, ХБ/ҮБ – 1 заалт, Хэрэгжилтийн хувь – 100%.** | | **Хасах санал: 10** |
| **Гурав. УИХ-ын Байнгын хорооны тогтоол** | | | | | |
| 9 | 14 | **Хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээний тухай**<br>2012-12-06, № 05<br>БОХХААБХ<br>1.Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д: Иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн байгаль орчныг хамгаалах ажил болон Орхон – Сэлэнгийн сав ба бусад нутгийг бохирдуулж буй цагаан тоосыг дарах үйл ажиллагаанд салбарын эрдэмтдийг татан оролцуулж, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр даруй гүйцэтгэх. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь ШУА-тай хамтын ажиллагааны хүрээнд байгаль орчны чиглэлээр “Цагаан тоосны тархалтын загварчлал”-ын ажлыг хийж байна.<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь цагаан тоосны дэгдэлтийг бууруулах, дарах зорилгоор 1/хаягдал булингыг дарагч бодистой барьцалдуулан тоосыг дарах, 2/тоос дарагч бодисыг устай хольж тусгай зориулалтын техник тоног төхөөрөмж ашиглан тоостой талбайд цацах, 3/үйлдвэрийн технологийн гэсэн гурван аргыг хослуулан 2020 онд Хаягдлын аж ахуйн талбайн тоос идэвхтэй дэгддэг 900 га хуурай талбайн 80 хувь буюу 720 га талбайн тоосжилтыг дарсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| 10 | 15 | **Чиглэл өгөх тухай**<br>2017-06-07, №15<br>ЭЗБХ | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>ТӨБЗГ-аас 2018 онд “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Ерөнхий сайд, Засгийн газарт 2018 оны 03 дугаар | “Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1.7/.Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өмч хөрөнгийн эзэмшил, ашиглалт, үр ашгийг сайжруулах үүднээс төрийн өмчийн хувьчлалыг үе шаттай, зохистой зохион байгуулах, ард иргэдэд үзүүлэх нийгмийн салбарын хүртээмж, үр өгөөжийг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авах. | сарын 21-нд хүргүүлсэн. Тус төслийг тухайн үед Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд 23 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 4 хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 27 хуулийн этгээдийг хувьчлах саналыг Улсын Их Хуралд 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ЗГ-1/112 дугаар албан бичгээр өргөн барьсан. Улсын Их Хурлаас саналыг хэлэлцээд Эдийн засгийн байнгын хорооны дэргэд дэд ажлын хэсэг байгуулан дахин нарийвчлан судлахыг даалгасан.<br>Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг эгүүлэн татах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан. | | |
| | 16 | **Чиглэл өгөх тухай**<br>2017-06-07, №15<br>ЭЗБХ<br>2.Энэ тогтоолын хэрэгжилтийн явцыг 2017 онд багтаан УИХ-ын ЭЗБХ-д танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Улсын Их Хурлын 2018 оны нэгдсэн хуралдаанаар “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн төслийг хэлэлцээд Эдийн засгийн байнгын хорооны дэргэд Дэд ажлын хэсэг байгуулан дахин нарийвчлан судлахыг даалгасантай холбогдуулан Б.Жавхлан гишүүнээр ахлуулсан ажлын хэсэгт ТӨБЗГ-аас холбогдох мэдээллийг гарган хүргүүлж байсан. Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эгүүлэн татах нь зүйтэй гэсэн шийдвэрлэсэн.<br>“Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдаагүй, хувьчлалын асуудлаар тодорхой бодлого, чиглэл гараагүй байна. | “Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| 11 | 17 | **Чиглэл өгөх тухай**<br>2017-06-07, №16<br>ЭЗБХ<br>2.4/.Төрийн өмчит аж ахуйн нэгжийн хувьцааг хөрөнгийн биржээр олон нийтэд арилжаалах, санхүүжилт босгохтой холбоотой үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн хувьцаа эзэмшигч БНСУ-ын “Кореа Телеком” корпорацийн өөрийн эзэмшлийн 40 хувь буюу 10,348,111 ширхэг хувьцааг Монголын Улсын Засгийн газарт гэрээний дагуу санал болгосныг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 300 дугаар тогтоолоор худалдаж авах шийдвэр гаргасан. Уг тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан багцын арилжаа явагдаж “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн төрийн эзэмшлийн хувь 94.67 хувь болон өөрчлөгдсөн. | “Хэрэгжих шатанд” – 70 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 18 | **Чиглэл өгөх тухай**<br>2017-06-07, №16<br>ЭЗБХ<br>2.5/. Санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа Засгийн газрын хөрөнгө оруулалттай байгууллагуудын хяналт, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх, давхардлыг арилгахад хамтран ажиллах; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зарим төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн менежментийг сайжруулах, зардлыг бууруулах, үйл ажиллагааны давхардлыг арилгах, ашигт ажиллагааг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт санал хүргүүлж, Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төрийн өмчит зарим хуулийн этгээдийг татан буулгах тухай” 9 дүгээр тогтоолыг гаргуулж, “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК, “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК, “Монгол тамга” ТӨҮГ, “Монгол тариалан” ТӨҮГ, “Монгол мах” ТӨҮГ-ыг татан буулгах ажлыг зохион байгуулсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| 12 | 19 | **Чиглэл өгөх тухай**<br>2018-04-25, Дугаар 2018 №08<br>ЭЗБХ<br>2.3/.Төрийн захиргааны холбогдох байгууллагуудтай хамтран статистикийн мэдээллийн чанар, үнэн зөв байдалд хяналт шалгалт хийх, шат шатны хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулах; | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн захиргааны статистикийн мэдээллийг нийслэл, 21 аймаг, төрийн өмчит 1000-аад хуулийн этгээдээс цуглуулан авч нэгтгэн Үндэсний статистикийн хороонд жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлж байна.<br>Мэдээллийн чанарыг сайжруулах, цахим хэлбэрээр тайлагнах боломжийг бий болгох чиглэлээр ҮСХ-ны албан хаагчидтай уулзалт зохион байгуулсан. Хамтран ажиллаж, мэдээллийн санг сайжруулах, тайлагнах хугацааг өөрчлөх талаар тодорхой саналууд гарган идэвхтэй ажиллаж байна. Энэ чиглэлээр Статистикийн улсын байцаагчийн эрхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2 албан хаагчид олгон хяналт тавих ажлыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| 13 | 20 | **Чиглэл өгөх тухай**<br>2018-05-02, №10<br>ЭЗБХ<br>1.11/.Төрийн өмчит аж ахуйн нэгжийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй гаргах, санхүүжилт босгохтой холбоотой үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн хувьцаа эзэмшигч БНСУ-ын “Кореа Телеком” корпорацийн өөрийн эзэмшлийн 40 хувь буюу 10,348,111 ширхэг хувьцааг Монголын Улсын Засгийн газарт гэрээний дагуу санал болгосныг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 300 дугаар тогтоолоор худалдаж авах шийдвэр гаргасан. Уг тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан багцын арилжаа явагдаж “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн төрийн эзэмшлийн хувь 94.67 хувь болон өөрчлөгдсөн. | “Хэрэгжих шатанд” – 70 % | |
| | | **УИХ-ын Байнгын хорооны тогтоол:<br>5 тогтоолын 7 заалт** | **100%-3 заалт; 70%-2 заалт; ХБ/ҮБ-2 заалт; Хэрэгжилтийн хувь – 88.0 хувь.** | | **Хасах санал: 0** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Дөрөв. Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | |
| 14 | 21 | **Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай**<br>2018-05-23, №46<br>3.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, идэвх санаачилгыг дэмжих талаар нийт албан хаагчдад сурталчилж, 2021 онд тодорхой арга хэмжээ авах талаар төлөвлөж байна. | “Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | | **Ерөнхийлөгчийн зарлиг:**<br>**1 зарлигийн 1 заалт.** | **ХБ/ҮБ – 1 заалт.** | | **Хасах санал: 0** |
| **Тав. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж** | | | | | |
| 15 | 22 | **Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай**<br>2017-07-19, №19/5<br>1.Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагаас мөнгө угаах, тероризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт энэ чиглэлээр үүссэн гомдол, маргаан бүртгэгдээгүй. Олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийг анхаарч, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.<br>Энэ зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг дараах удирдлага, чиглэлээр хаңган ажиллав. Үүнд:<br>– Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Монголбанканд гадаад валют худалдах зарим арга хэмжээний тухай” 03/03/А5 дугаар хамтарсан тушаалаар Төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн үйл ажиллагааны явцад бий болсон гадаад валютыг Монголбанкны тухайн өдрийн зарласан ханшаар Монголбанкинд худалдаж байх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан. Хамтарсан тушаалын | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэвшсэн тул цаашид хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилтийг хангуулахаар ТӨБЗГ-ын 2019 оны 01-р сарын 14-ний өдрийн “Тушаалын хэрэгжилтийг хангуулах тухай” А-1/89 дүгээр албан бичгийг нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 94 хуулийн этгээдэд хүргүүлсэн. 2020 оны тайлант хугацааны байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс нийт 1,067,012,600.0 ам.доллар (“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ – 657,500,000.0 ам.доллар, “Монголросцветмет” ТӨҮГ – 46,300,000.0 ам.доллар, “Эрдэнэс Тавантолгой” ХХК – 363,212,600.0 ам.доллар)-ыг Монголбанкинд арилжсан дүнтэй байна.<br>– Төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын мөнгөн урсгал, түүний хөдөлгөөнд хяналт тавьж, Монголбанкины зохист шалгуур хангасан арилжааны банкинд тухайн компани, үйлдвэрийн газрын чөлөөт мөнгөн үлдэгдлийг байршуулж чиглэл өгч ажилласан.<br><br>Төрийн өмчит компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын хандив, тусламж, зээлийн хөрөнгийн эх үүсвэрийг тухайн компани, үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг дүгнэх явцад тухай бүр хяналт тавьж байгаа болно. | | |
| 16 | 23 | **Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын талаар авах арга хэмжээний тухай**<br><br>2020-11-13, №26/16<br><br>1.Дэлхий нийтэд тархаад байгаа коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахал иргэдийн дунд илэрч, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан гамшгийн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хохирлын хэмжээг бууруулах, цар тахлын халдварын тархалтыг зогсоох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг шуурхай зохион байгуулах. | **ТӨБЗГ – ЗУХ, ТӨУЗХ, Шуурхай штаб**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын шийдвэр, “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний удирдамж”, холбогдох бусад шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг аван ажилласан. Энэ хүрээнд ТӨБЗГ-ын даргын 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/74 дүгээр тушаалаар байгууллагын Шуурхай штабыг шинэчлэн байгуулж, гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө гарган шаардлагатай төсвийг бэлэн байдлыг хангах, нөөцийг бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын хэрэгслээр хангахад зарцуулахаар шийдвэрлэв. ТӨБЗГ нь энэ чиглэлийн үйл ажиллагаанд зориулж, 2020 онд нийт 6.5 сая төгрөгийн төсвийг зарцуулсан байна. Мөн газрын даргын 2020 оны А/71, А/80 дугаар тушаалаар байгууллагын үйл ажиллагааг тусгай горимд шилжүүлж, 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй албан хаагчдаас бусад албан хаагчдын ажиллах хуваарийг батлан, байгууллагад цөөн тооны албан хаагчдыг ээлжээр ажиллуулж байна. Бүх нийтийн хол хорио тотоосон үед батлагдсан | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Хэвшиж байгаа ажил тул цаашид хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хуваарийн дагуу ээлжээр ажиллахаас бусад үед албан хаагчид гэрээсээ цахимаар ажиллах зохион байгуулалтын арга хэмжээ аван төрийн байгууллагын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг ханган ажиллав. Хурал, уулзалтыг цахим хэлбэрээр хийх техникийн шийдлийг бий болгон зайнаас зохион байгуулж байна.<br><br>Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссын холбогдох шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах, цар тахалтай тэмцэх, сэргийлэх, хол хорио тотоосон үед үйл ажиллагааныхаа хэвийн байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмээ авч ажиллах чиглэлээр 9 заалт бүхий албан даалгаврыг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 92 хуулийн этгээдэд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А-1/2004 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Мөн Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний тухай” 183 дугаар тогтоолын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар чиглэлийг төрийн өмчит нийт 90 компани, үйлдвэрийн газарт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын А-1/2041 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. | | |
| | | **ҮАБЗ-ийн 2 зөвлөмжийн 2 заалт:** | **100 % - 2 заалт, Хэрэгжилтийн хувь – 100%.** | | **Хасах санал: 2** |
| **Зургаа. Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 17 | 24 | **Төрийн өмчит үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулах тухай**<br><br>2013-10-05, № 336<br><br>3.Монгол Улс ба Нордикийн хөгжлийн сан хооронд байгуулсан зээлийн хэлэлцээрийн хүрээнд олгосон зээлийн үлдэгдлийн тооцоог гаргаж баталгаажуулах, Автотээврийн үндэсний төвтэй дамжуулан зээлдүүлэх гэрээг шинэчлэн байгуулж зээлийн эргэн төлөлтийг тус төвийн жил бүрийн зорилтот түвшинд тусган барагдуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаан, Зам, тээврийн сайд А.Гансүх нарт даалгасугай. | **ТӨБЗГ - ТӨУЗХ**<br><br>2001 онд 3,940,000.0 SDR–тэй /ЗТЭ/ тэнцэх зээлийг Тээвэр хөгжүүлэх төслийн хүрээнд хуучнаар Санхүү, эдийн засгийн яам ба Авто тээврийн газрын хооронд байгуулсан NDF-353 дугаартай гэрээний дагуу Нордикийн хөгжлийн сангаар дамжуулан зээлийг олгосон. Санхүү, эдийн засгийн яам (хуучнаар), Авто тээврийн газрын хооронд 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан 122/11/55/ дугаар гэрээний хавсралт дахь дамжуулан зээлдүүлэхэд өөрчлөлт оруулан зээлийн төлбөрийн хуваарийг шинэчлэн, зээлийг төлж эхэлсэн.<br><br>“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын жил бүрийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусган зээлийн төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажилласан.<br><br>2020 оны эхний хагас жилийн төлбөр болох 67,786.5 SDR /ЗТЭ/ | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | буюу 263,6 сая төгрөгийг 2020.06.19-ны өдөр Сангийн яамны Төрийн сангийн дансанд, мөн 2020 оны сүүлийн хагас жил болон 2021 оны бүтэн жилийн төлбөр болох 201,560.13 SDR буюу нийт 807.3 сая төгрөгийг 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдөр тус тус төлсөн. Үүний 179,964.00 SDR буюу 720.8 сая төгрөг нь үндсэн зээлийн төлбөр 21,696.13 SDR буюу 86.9 сая төгрөг нь хүүгийн төлбөр болно. 2021 оныг дуустал зээлийн үндсэн төлбөр болон хүүг төлж дуусгасан.<br><br>Зээлийн нийт үлдэгдэл 1,439,754.01 SDR буюу 5.6 тэрбум төгрөг байна. | | |
| 18 | 25 | **Хувьцааны хөрөнгө шийдвэрлэх тухай**<br><br>2017-10-25, № 300<br><br>3. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн менежментийг сайжруулан үйл ажиллагааг нь дэмжиж, үр ашигтай ажиллуулах талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), Харилцаа холбооны зохицуулах хороо (С.Адъяасүрэн), Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2018 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн менежментийг сайжруулан үйл ажиллагааг нь дэмжиж, үр ашигтай ажиллуулах талаар холбогдох арга хэмжээ авч, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэг бүхий Сангийн яам, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл оролцсон ажлын хэсэг байгуулан ажиллуулсан.<br><br>Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 1/778 дугаар албан бичгээр “Монголын цахилгаан холбоо” ХК-д өгсөн нийт 5 зөвлөмжийг хэрэгжүүлэх хүрээнд тус компани төрийн өмчийн болон төрийн байгууллагуудад үйлчилгээ хүргэх, өргөжүүлэх чиглэлээр багцын үйлчилгээ нэвтрүүлэх, өргөн зурвасын утасгүй суурин интернэтийн сүлжээ байгуулах (LTE), үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл авах, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-тай байгуулсан холбогдох гэрээнүүдийг шинэчлэх, ашиглалтыг сайжруулах, компанийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ОТТ үйлчилгээ нэвтрүүлэх төслийг тусган хэрэгжилтийг хангах зэрэг ажлуудыг гүйцэтгэж байна. Мөн Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхээр “Монголын цахилгаан холбоо” ХК нь 28 суманд төрийн үйлчилгээг операторын горимоор ажиллуулах төлөвлөгөө гарган ажиллаж, зөвлөмжийн биелэлтийг тухай бүр тайлагнан ажилласан.<br><br>2019 онд тус компани нь 19.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийж, 19.5 тэрбум төгрөгийн зардал гарган 62.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Суурин утасны 4572, кабелийн телевизийн | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3326 шинэ хэрэглэгч холбосон үр дүнтэй байна. | | |
| 19 | 26 | **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай**<br>2018-01-10, № 8<br>2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үр ашгийг дээшлүүлэх талаар дараах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай: 2.1.компанийн засаглалыг сайжруулж, ил тод, нээлттэй байдлыг хангах, үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бий болгох; 2.2.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байх; 2.3.удирдлага, менежментийг сайжруулах, үргүй зардлыг багасгах зорилгоор төрийн өмчит зарим хуулийн этгээдийг нэгтгэх, татан буулгах, өөрчлөн зохион байгуулах; 2.4. төрийн өмчийн үр өгөөжийг сайжруулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, ажил дүгнэх шалгуур үзүүлэлт, түүнийг дүгнэх аргачлалыг шинэчлэн боловсруулж, батлан мөрдүүлэх; 2.5.компанийн удирдлага, ажиллагсдын цалин хөлс, урамшууллын тогтолцоог компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагаа, төрд төлсөн ногдол ашигт тулгуурлан тооцох аргачлал гаргаж | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>2.1.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдалд аудит хийн, шилэн дансны цэсийн мэдээллийг тогтмол шинэчлэн олон нийтэд хүргэх талаар зөвлөмж, чиглэл хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьсан.<br>2.2.Төрийн өмчийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд энэ асуудалд хяналт тавьж ажиллав.<br>2.3.Төрийн өмчит зарим хуулийн этгээдийн удирдлага, менежментийг сайжруулах, үргүй зардлыг багасгах зорилгоор Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төрийн өмчит зарим хуулийн этгээдийг татан буулгах тухай” 9 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>2.4."Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 260 дугаар тогтоолоор батлуулсан. Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх захиралтай байгуулах контрактын загвар, төрийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулах контрактын загварт орсон өөрчлөлтийг мөрдөж байна.<br>2.5.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу компанийн удирдлага, ажиллагсдын цалин хөлс, урамшууллын тогтолцоог компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагаа, төрд төлсөн ногдол ашигт тулгуурлан тооцож байна.<br>2.6.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага, өглөгийг бууруулах талаар албан даалгавар хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллав. Тэдгээрийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг авлага, өглөгийг бууруулах зарчмыг баримтлан баталж, хэрэгжилтийг хангуулав.<br>2.7.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн өмчит | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжилт тогтмолж-сон тул цаашид хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | мөрдүүлэх; 2.6.өр, авлага болон дамжуулан зээлдүүлэх гэрээний хүүг бууруулах талаар тодорхой арга хэмжээг үе шаттайгаар авах; 2.7.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулж, дотоодын үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг тэргүүн ээлжинд авах боломжийг бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. | болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулан ажиллах талаар хяналт шалгалтын ажлын хүрээнд хяналт тавих, чиглэл, зөвлөмжөөр ханган ажиллав. | | |
| 20 | 27 | **“Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал” шинэчлэн батлах тухай**<br>2018-01-24, № 20<br>4. Хөгжлийн индексийн үр дүнг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлт боловсруулахад ашиглаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, тухайн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн төсөвт олгох хөрөнгийг хөгжлийн индекс ашиглан тодорхойлсон итгэлцүүрийг үндэслэн тооцож байхыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Тус байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй байна. | “Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй” – ХБ. | Тус байгууллагын чиг үүрэгт хамаарах-гүй байна.<br>Хяналтаас хасуулах саналтай. |
| 21 | 28 | **“Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай**<br>2018-03-27, № 81<br>1. “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй хавсралтад заасан орон сууцны дуусаагүй барилгыг хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрт нь тооцон Хөгжлийн банкинд шилжүүлэх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Засгийн газрын 2018 оны 81 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд 82.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий орон сууцыг Түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн. Барилга, хот байгуулалтын яам болон “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн хооронд 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан №2019/194, 219/4-15 тоот гэрээний дагуу 5.0 тэрбум төгрөгийг Монгол Улсын Хөгжлийн банкинд 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр шилжүүлж, “Буянт-Ухаа 2” хорооллын үндсэн зээлийн төлбөрт төлсөн.<br>Мөн БХБЯ-ны 2020 оны төсөвт 5.0 тэрбум төгрөг тусгагдсан бөгөөд үүнийг гэрээний дагуу Хөгжлийн банкинд 2020 онд төлнө. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дарга Ц.Ням-Осор нарт тус тус даалгасугай. | | | |
| 22 | 29 | **Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2018-08-01, № 232<br>2. “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-тай хамтарсан төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>ТӨБЗГ-аас 2018 онд өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу “Монголын төмөр зам” ТӨХК нь “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн гэрээний гол нөхцөл, гэрээний төслийг тухайн үед боловсруулан “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-д хүргүүлж байсан. Төмөр замын царигийн асуудлыг УИХ-аас эцэслэн шийдвэрлэсний дараа уг асуудлаар санал солилцохоор болсон.<br>2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар “Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын царигийг 1435 мм-ээр тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалыг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу УИХ-аас шийдвэр гаргуулахаар ажилласан.<br>УИХ-ын ЭЗБХ-ны 2019 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдаанаар Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын царигийн асуудлыг хэлэлцэж, “УИХ-ын 2014 оны 64 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр шийдвэр гаргасан. 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн УИХ-ын чуулганаар УИХ-ын 2014 оны 64 дүгээр тогтоолыг хүчингүй болгосон. Ингэснээр Монгол Улсын төмөр замын бүх чиглэл 1520 мм-ийн царигтай болох асуудал шийдвэрлэгдсэн. | “Хэрэгжилт хангалтгүй” – 30%. | |
| 23 | 30 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай: 1.1. харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт | **ТӨБЗГ – ЗУХ, бүх хэлтэс, алба**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын нэг албан хаагчийн албан үүрэгт холбогдох асуудлаар мэдээлэл хүлээн авсны дагуу газрын даргын 2020 оны А/24 дүгээр тушаалаар нэр бүхий албан хаагчийн ажил, үүргийн хэрэгжилт, сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл байгаа эсэхийг шалган тогтоох үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан. Ажлын хэсгийн дүгнэлтээр сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлтэй гэж үзсэн тул тухайн албан хаагчид газрын даргын 2020 оны Б/48 дугаар тушаалаар сануулах сахилгын шийтгэл ногдуулсан байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тайлагнаж байх; | | | |
| | 31 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1.3. төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах; | **ТӨБЗГ – ЗУХ, бүх хэлтэс, алба**<br>2020 онд “Байгууллагын чиг үүргийн шинжилгээ”, “Ажлын байрны шинжилгээ”-г Төрийн албаны хууль тогтоомжийн дагуу албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрөл авахтай холбоотойгоор 2 удаа хийж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна.<br>1.Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Агентлаг байгуулах тухай” 438 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэг өөрчлөгдөж, Ерөнхий сайдын 2020 оны 06 дугаар захирамжаар байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэн батлагдсан. “Байгууллагын чиг үүргийн шинжилгээ”, “Ажлын байрны шинжилгээ”-ээр ажлын давхардал үүсэхгүй байна, харин тус байгууллагын орон тооны дээд хязгаарыг “31” байхаар Засгийн газрын 2019 оны 438 дугаар тогтоолоор баталсантай холбоотойгоор албан хаагчдын ажлын 2 дахин ачаалал ихэссэнээс зарим чиг үүргийн хийдэл гарч, байгууллагын үйл ажиллагаанд болон албан хаагчдын нийгмийн асуудалд тодорхой эрсдэл үүсэх нөхцөл байдал үүсч болзошгүй байна гэж дүгнэсэн.<br>Төрийн захиргааны 14 албан тушаалын тодорхойлолтыг хянаж, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 102 дугаар тогтоолоор батлах зөвшөөрөл олгосныг үндэслэн төрийн захиргааны 14, төрийн үйлчилгээний 3 албан тушаалын тодорхойлолтыг батлан мөрдүүлсэн.<br>2.Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолоор ТӨБЗГ-ын орон тоо “55” болж нэмэгдсэнтэй холбоотойгоор Ерөнхий сайдын 2020 оны 79 дүгээр захирамжаар байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц өөрчлөгдсөн. Үүнтэй холбоотой мөн дээрх судалгаа шинжилгээг дахин хийж, дүгнэлт санал боловсруулан албан хаагчдын ажлын ачаалал, хуваарилалтыг оновчтой болгох асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авав. Төрийн захиргааны нийт 20 албан тушаалын тодорхойлолтын төслийг Төрийн албаны зөвлөлд хянуулан батлах зөвшөөрөл авахаар хүргүүлсэн. Төрийн үйлчилгээний 9 албан тушаалын тодорхойлолтыг газрын даргын тушаалаар батлан мөрдүүлэв. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжиж хэвшсэн тул хяналтаас хасах саналтай. |
| | 32 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай** | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Агентлаг байгуулах тухай” 438 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын | “Бүрэн | Төрийн албаны тухай хууль тогтоом- |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2018-08-22, № 258<br><br>1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх; | газрын чиг үүрэг өөрчлөгдөж, Ерөнхий сайдын 2020 оны 06 дугаар захирамжаар байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэн батлагдсан. Үүнтэй холбогдуулан тус байгууллагын Төрийн өмчийн бүртгэлийн хэлтсийн дарга, Захиргаа, удирдлагын албаны дарга, Хууль, эрх зүйн албаны даргын албан тушаалд Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлах захиалгыг Төрийн албан зөвлөлд өгсөн. Сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын дагуу Төрийн албаны зөвлөлөөс зарлан, тусгай шалгалтыг 2020 оны 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Сонгон шалгаруулалтын үр дүнд Төрийн албаны зөвлөлөөс дээр дурдсан 3 албан тушаалд нэр дэвшүүлсэн нэр дэвшигчдийг ТӨБЗГ-ын даргын тушаалаар тус тус томилсон.<br><br>Засгийн газрын 2020 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 144 дүгээр тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын орон тоон дээд хязгаар “55” байхаар тогтоосонтой холбоотой Ерөнхий сайдын 2020 оны 79 дүгээр захирамжаар зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдсэн. Байгууллагын бүтэц орон тооны өөрчлөлттэй холбоотойгоор Төрийн албаны тухай хууль болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын дагуу төрийн өөр байгууллагаас 3 албан хаагчийг шилжүүлэн ажиллуулсан. | хэрэгжсэн” – 100% | жийн хэрэгжил-тийг хангах ажил хэвшин тогтмол-жиж байгаа тул хяналтаас хасах саналтай. |
| | 33 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br><br>2018-08-22, № 258<br><br>1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган | **ТӨБЗГ – ЗУХ, бүх хэлтэс, алба**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ыг газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/163 дугаар тушаалаар шинэчлэн баталж, уг журмын 7.2.3-т ажлын байр, хууль, журмаар тогтоосон албан үүрэгтэй холбоотой газар ажлын болон ажлын бус цагаар согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглосон заалт оруулсан.<br><br>Харуул хамгаалалтын албаны ажилтнууд байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэхгүй байхад анхааран байнга хяналт тавьж | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэвшиж тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох; | байгаа.<br>2020 онд албан хаагчид ажлын болон ажлын бус цагаар ажлын байр, томилолтоор ажиллах явцад согтууруулах ундаа хэрэглэх, бусад ёс зүйн зөрчил гараагүй болно. | | |
| | 34 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах; | **ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗА, бүх хэлтэс, алба**<br>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэргэд ажиллах “Ёс зүйн зөвлөл”-ийг хэлтэс, алба болон нийт албан хаагчдын саналыг үндэслэн агентлагийн даргын 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/10 дугаар тушаалаар байгуулж, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг агентлагийн даргын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/15 дугаар тушаалаар батлан мөрдүүлсэн.<br>2020 онд ёс зүйн аливаа зөрчил, гомдол, мэдээлэл бүртгэгдээгүй бөгөөд ёс зүйн зөвлөлийн ажлын тайлан, мэдээг Төрийн албаны зөвлөлд улирал бүр хүргүүлэн мэдээлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Хэвшиж тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай. |
| | 35 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1.9. төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах; | **ТӨБЗГ – ЗУХ, бүх хэлтэс, алба**<br>Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг дотоод сүлжээ, цаг бүртгэлийн төхөөрөмж, хяналтын камерын системээр бүртгэдэг бөгөөд хяналтыг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах, зөрчил, доголдлыг арилгахад чиглэсэн ажлыг цалинтай уялдуулах замаар зохион байгуулж хэвшсэн бөгөөд Шинэ коронавируст халдварын цар тахлын үеэр авч хэрэгжүүлж байгаа хорио цээрийн дэглэмтэй холбоотойгоор албан хаагчдын цагийн бүртгэлийн горимыг түр хугацаанд өөрчлөн зохион байгуулж байгаа. Албан хаагчдын цагийн бүртгэлийг цаасан суурьтай бүртгэлээр өдөр бүр бүртгэж, 7 хоног, сараар зохион байгуулалтын нэгжийн дарга нараар хянуулан баталгаажуулж, хяналт тавьж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэвшиж тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай. |
| | 36 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар | **ТӨБЗГ – ЗУХ, бүх хэлтэс, алба**<br>Ажлын байран дахь хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг гаргахгүй, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх зорилгоор “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ыг газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/163 дугаар тушаалаар шинэчлэн баталж, уг журмын газрын эдлэх эрх, хүлээх үүрэг буюу 7.1.8-д “Албан хаагчийн нэр төрд халдах, доромжлох | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэвшиж тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах; | зэрэг аливаа зүй бус үйлдэл гаргахгүй байх үүрэгтэй", 7.1.9-д "Албан хаагчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөл болон хууль тогтоомжоор тогтоосон бусад баталгаагаар хангах үүрэгтэй" байхаар зохицуулсан. Дотоод журам, албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>Албан хаагчдын ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл, ёс зүйн зөрчил бүртгэгдээгүй болно. | | |
| | 37 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br><br>2018-08-22, № 258<br><br>3. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ЗУХ, бүх хэлтэс, алба**<br><br>Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг дотоод сүлжээ, цаг бүртгэлийн төхөөрөмж, хяналтын камерын системээр бүртгэдэг бөгөөд хяналтыг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах, зөрчил, дутагдлыг арилгахад чиглэсэн ажлыг цалинтай уялдуулах замаар зохион байгуулж хэвшсэн боловч Шинэ коронавируст халдварын цар тахлын үеэр авч хэрэгжүүлж байгаа хорио цээрийн дэглэмтэй холбоотойгоор албан хаагчдын цагийн бүртгэлийн горимыг түр хугацаанд өөрчлөн зохион байгуулж байгаа. Албан хаагчдын цагийн бүртгэлийг цаасан суурьтай бүртгэлээр өдөр бүр бүртгэж, 7 хоног, сараар зохион байгуулалтын нэгжийн дарга нараар хянуулан баталгаажуулж, хяналт тавьж байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | Хэвшиж тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай. |
| 24 | 38 | **Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай**<br><br>2018-09-12, № 286<br><br>1. Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх 5986 м.кв талбай бүхий 5 барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 59 дүгээр тогтоолоор Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5 барилга байгууламжийг газар эзэмших эрхийн хамт 17,333,000,000.00 (Арван долоон тэрбум гурван зуун гучин гурван сая) төгрөгөөр нээлттэй дуудлагын худалдааны журмаар худалдахаар шийдвэрлэсэн. 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн "Өнөөдөр", "Зууны мэдээ", "Засгийн газрын мэдээ" сонин болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын www.pcsp.gov.mn цахим хуудсанд зар мэдээг байршуулж, олон нийтэд зарлан мэдээлсэн. 2019 оны 03 дугаар сараас 12 дугаар сарын хугацаанд нээлттэй дуудлага худалдааг нийт 7 удаа зохион | "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | байгуулахад аль ч тохиолдолд нэг ч оролцогч ирээгүй байна.<br><br>Уг үл хөдлөх хөрөнгийн 7 удаагийн дуудлага худалдааг зохион байгуулах явцад ТӨБЗГ-ын 2016 оны “Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 128 дугаар тогтоолын 5.4-т заасны дагуу худалдах доод үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 121, 366, 479 дүгээр тогтоолоор тус тус үе шаттай бууруулж, 11,245,000,000.00 (арван нэгэн тэрбум хоёр зуун дөчин таван сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, нээлттэй зарласан боловч үр дүн гараагүй. Иймээс Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны шинэ конторын барилгын асуудлыг шийдвэрлүүлэх хүрээнд энэхүү Засгийн газрын 2018 оны 286 дугаар тогтоолыг хүчингүй болгох саналыг боловсруулаад байгаа болно. | | |
| 25 | 39 | **“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах тухай**<br><br>2018-10-31, № 328<br><br>3. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, компанийн өр, авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор) нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Хөгжлийн банкны зээлээр барьж буй байруудыг “Түрээсийн орон сууц” хөтөлбөрт хамруулах тухай Засгийн газрын 2018 оны 81 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан 82.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий орон сууцыг Түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн.<br><br>Барилга, хот байгуулалтын яам болон “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн хооронд 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан №2019/194, 219/4-15 тоот гэрээний дагуу 5.0 тэрбум төгрөгийг Монгол Улсын Хөгжлийн банкинд 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр шилжүүлж, “Буянт-Ухаа 2” хорооллын үндсэн зээлийн төлбөрт төлсөн. | “Хэрэгжих шатанд” - 70% | |
| 26 | 40 | **Дүрэм батлах тухай**<br><br>**“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм**”<br><br>2019-01-23, № 33<br><br>2.Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ЗУХ, ХЭЗХ**<br><br>Засгийн газрын 2019 оны “Агентлаг байгуулах тухай” 438 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэг өөрчлөгдөж, Ерөнхий сайдын 2020 оны 06 дугаар захирамжаар байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэн батлагдсантай холбоотой байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг шинэчлэх ажлыг байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авсан.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэргэд ажиллах “Ёс зүйн зөвлөл”-ийг хэлтэс, алба болон нийт албан хаагчдын саналыг | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | үндэслэн агентлагийн даргын 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/10 дугаар тушаалаар байгуулж, “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг агентлагийн даргын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/15 дугаар тушаалаар батлан мөрдүүлсэн.<br><br>Засгийн газрын 2020 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 144 дүгээр тогтоол, Монгол улсын Ерөнхий сайдын 2020 оны 79 дүгээр захирамжаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэн батлагдсан, төрийн албаны нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад хууль тогтоомжид өөрчлөлт орсонтой холбогдуулан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн боловсруулах шаардлага үүсч, журмын төсөлд албан хаагчдаас санал авах, судалгаа хийх ажлуудыг хийж байна. | | |
| 27 | 41 | **“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2019-03-06, № 91<br><br>2.3. үндсэн ба эргэлтийн хөрөнгө, түүний дотор түүхий эд, материалын нийлүүлэлт, зарцуулалт, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хадгалалт, хуваарилалт, тээвэрлэлт, борлуулалтад тусгай хяналт тогтоож ажиллахыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхбат нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Үндсэн ба эргэлтийн хөрөнгө, түүний дотор түүхий эд, материалын нийлүүлэлт, зарцуулалт, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хадгалалт, хуваарилалт, тээвэрлэлт, борлуулалтад тусгай хяналт тогтоон ажилласан.<br><br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ: Үйлдвэрлэлийн тасралтгүй найдвартай ажиллагааг ханган, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эрдэс баялгийн боловсруулалтын технологийн түвшнийг дээшлүүлж, орд газрын нөөцийг бүрэн ашиглаж, үйлдвэрлэлийн хэмжээ, үр ашгийг нэмэгдүүлэх зорилт тавьж ажилласны үр дүнд 2019 онд үйлдвэрлэлийн төлөвлөгөөт бүх үзүүлэлтүүдийг 100-аас дээш хувиар биелүүлэн, 37.2 сая тн хүдэр олборлож, 32.2 сая тн хүдэр боловсруулсан нь Эрдэнэт үйлдвэрийн түүхэн дэх хамгийн өндөр үзүүлэлт болсон. 2019 онд хүдэр олборлолтын төлөвлөгөөг 3.3 хувиар, хүдэр боловсруулалтыг 2.2 хувиар тус тус давуулан биелүүлж, 2018 онтой харьцуулахад хүдэр олборлолтыг 600 мян.тн, хүдэр боловсруулалтыг 680 мян.тн-оор тус тус нэмэгдүүлсэн.<br><br>“Монголросцветмет” ТӨҮГ: 2019 онд жоншны хүдэр 80.7 мян.тонныг боловсруулан, ФФ-95 маркийн флотацын баяжмал 15.9 мян.тн, ФК-75 маркийн металлургийн баяжмал 182 тн үйлдвэрлэж, гадны компанитай хамтран ажиллах гэрээний дагуу 379 тн ФК-75 маркийн металлургийн баяжмал нийлүүлэгдэж, флотацын баяжмал 21.7 мян.тн, металлургийн баяжмал 605 тонныг тус тус экспортод гаргасан. Мөн хугацаанд 2,721.6 мян.м$^3$ хөрс хуулж, 2,437.6 мян.тн | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Дараачийн шийдвэр буюу Засгийн газрын 2020 оны 127 дугаар тогтоол, Засгийн газрын хуралдаа-ны 56 дугаар тэмдэглэл гарсан тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | төмрийн хүдэр олборлон, хуурай соронзон аргаар 52 %-ийн агуулгатай төмрийн хүдрийн хуурай баяжмал 198.8 мян.тн, нойтон соронзон сепарацийн аргаар 66%-ийн агуулгатай төмрийн хүдрийн нойтон баяжмал 189.9 мян.тонныг тус тус үйлдвэрлэсэн. 52% агуулгатай төмрийн хүдрийн хуурай баяжмалын борлуулалт 198.1 мян.тн, 66% агуулгатай төмрийн хүдрийн нойтон баяжмалын борлуулалт 166.8 мян.тн байна. Технологийн хувьд Баргилтын төмрийн хүдрийн ил уурхайн жилийн олборлолтын хүчин чадлыг ТЭЗҮ -д тусгагдсанаар 2.4 сая тоннд хүргэх зорилгоор 4.5 $м^3$ шанагатай Либхер 966R экскаватор 1, JK-730 өрмийн машин 2-ыг шинээр худалдан авч ашиглалтад оруулсан. | | |
| | 42 | **“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2019-03-06, № 91<br>2.4. шаардлагатай бол тухайн компанид хөдөлмөрийн болон үйлдвэрлэл, технологийн сахилгыг чанд сахин биелүүлэхэд чиглэсэн хөдөлмөрийн сахилгын тухайлсан дүрэм, үйлдвэрлэлийн аюул осолгүй ажиллагааны болон олон нийтийн хэв журам сахиулах тусгай журам тогтоож, тэдгээрийг зөрчигчдөд зохих хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхбат нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Тухайн компанид хөдөлмөрийн болон үйлдвэрлэл, технологийн сахилгыг чанд сахин, үйлдвэрлэлийн аюул осолгүй ажиллагааны болон олон нийтийн хэв журам сахиулан ажиллаж байна. Үйлдвэрийн бүсийн харуулын цэгүүд, үйлдвэрийн обьектод цагдаагийн алба хаагчдыг ээлжээр ажиллуулж, өдөр бүр эргүүлийн үүрэг гүйцэтгүүлж байгаа.<br>“Монголросцветмет” ТӨҮГ-ын зүгээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зөрчил гаргахгүй байх, цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Мөн үйлдвэрлэл, технологийн болон хөдөлмөрийн сахилгыг чанд сахин биелүүлэх, компанийн бүс, обьектод хүн, тээврийн хэрэгсэл шалган нэвтрүүлэх журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулсан.<br>“Монголросцветмет” ТӨҮГ нь өөрчлөн зохион байгуулагдсантай холбоотойгоор үйлдвэрийн хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм, журмыг шинэчлэх ажлын хэсгийг байгуулж, шаардлагатай дүрэм, журам, зааврыг шинэчлэх ажлыг хийсэн. Тухайлбал, Хөдөлмөрийн дотоод журам, Нууцын журам, Албан хэрэг хөтлөлтийн журам, Архивын ажлын заавар, Гэрээ байгуулах журам, “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа алтны үйлдвэрүүдэд алт хамгаалах тухай журам, Орон сууцыг эзэмшүүлэх тухай журам, Үйлдвэрлэлийн ослоор амь насаа алдсан ажилтны гэр бүлд мөнгөн тусламж олгох тухай журмыг тус тус шинэчлэн баталж мөрдүүлсэн байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Дараачийн шийдвэр буюу Засгийн газрын 2020 оны 127 дугаар тогтоол, Засгийн газрын хуралдаа-ны 56 дугаар тэмдэглэл гарсан тул хяналтаас хасах саналтай. |
| | 43 | **“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай** | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>2019 онд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ нь Засгийн газраас тогтоосон онцгой дэглэм, үйлдвэрийн газрын эрх | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | Дараачийн шийдвэр буюу Засгийн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2019-03-06, № 91<br><br>2.6. онцгой дэглэмтэй компанийн эрх ашиг сонирхолд нийцээгүй гэрээг талуудын хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүйгээр өөрчлөх буюу цуцлах арга хэмжээ авч ажиллахыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхбат нарт; | ашиг сонирхолд нийцээгүй гэрээ байгуулаагүй болно.<br><br>“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ны үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК, “Кью Эс Си” ХХК, “Цемент шохой” ХК, “Монголиан коппер корпорэйшн” ХХК, “Цэц мөнх” ХХК, “Рэс” ХХК, "Гурван уул" ХХК, "Тайтлан Ресорсиз Монголиа" ХХК зэрэг хуулийн этгээдтэй холбоотой зарим асуудлыг шалгуулах нь зүйтэй гэж үзэж хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн.<br><br>Стандарт банктай холбоотой хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэх талаар Засгийн газраас чиглэл, удирдамж өгч ажилласны дүнд 2019 оны 04 дүгээр сарын эхээр 40.0 сая ам.долларыг Стандарт банкинд төлж, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын гадаад дахь өр төлбөрийн асуудал хаагдсан бол дотооддоо энэ асуудал хууль хяналтын байгууллагуудаар шалгагдаж, шүүхийн шатанд хянагдаж байна.<br><br>Онцгой дэглэм тогтоосноор үйлдвэрийн газрын үйл ажиллагаа жигдэрсэн бөгөөд шалгалтын актаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хууль зөрчсөн, ашиг сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхэд тодорхойгүй хугацаа шаардагдахаар байгаа болно. | | газрын 2020 оны 127 дугаар тогтоол, Засгийн газрын хуралдаа-ны 56 дугаар тэмдэглэл гарсан тул хяналтаас хасах саналтай. |
| | 44 | **“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2019-03-06, № 91<br><br>2.7. хууль тогтоомжоор улс, орон нутгийн төсөвт төлөх татвар, хураамж, ногдол ашгийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, хариуцлага тооцож ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат), “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхбат нарт. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Хууль тогтоомжийн хүрээнд улс, орон нутгийн төсөвт төлөх татвар, хураамж, ногдол ашгийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Эдгээр үйлдвэрийн газруудын 2018 оны жилийн эцсийн цэвэр ашгийн дүнгээс тооцон тогтоосон төрийн өмчийн ногдол ашгийг Улсын төсөвт төвлөрүүлсэн. Үүнд, ТӨБЗГ-ын 2019 оны 231 дүгээр тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-аас “Ирээдүйн өв сан”-д нийт 151,568.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тогтоож шийдвэрлэсэн бөгөөд 2019 оны жилийн эцсийн дүнгээр “Ирээдүйн өв сан”-д төвлөрүүлэх төрийн өмчийн ногдол ашгийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн болно. 2020 онд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ 155.0 тэрбум төгрөгийн, “Монголросцветмет” ТӨҮГ 5.1 тэрбум төгрөгийн, нийт 160.1 тэрбум төгрөг (2019 оны цэвэр ашгаас тогтоосон)-ийн төрийн өмчийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлсний 155.0 тэрбум төгрөг нь “Ирээдүйн өв сан”-д төвлөрсөн болно.<br><br><u>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ:</u> 2019 онд 2.2 их наяд төгрөгийн борлуулалтын орлого олж, төлөвлөгөөг 112.6 хувиар биелүүлэн, | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Засгийн газрын 2020 оны 127 дугаар тогтоол, Засгийн газрын хуралдаа-ны 56 дугаар тэмдэглэл гарсан тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөгөөт нийт зардлыг 1.4 хувиар бууруулж, 493.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь улс, орон нутгийн төсөвт 2019 онд нийт дүнгээр 961.8 тэрбум төгрөгийн төлбөр, татвар, хураамж төлсөн байна.<br><br>“Монголросцветмет” ТӨҮГ: 2019 онд 143,855.3 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 106,364.9 сая төгрөгийн зардал гарган, 34,446.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу 2017 оны ногдол ашгийн дутуу төлөлт, 2018 оны цэвэр ашгаас тооцсон ногдол ашигт нийт 2,939.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Улс, орон нутгийн төсөвт татвар, төлбөр хэлбэрээр 22,090.5 сая төгрөгийг төлөхөөр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 33,369.4 сая төгрөгийг төлсөн байна. | | |
| 28 | 45 | **Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай**<br><br>2019-03-21, № 111<br><br>2.Бүх шатны төсвийн байгууллага, төрийн буюу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэн ажиллах хүсэлт гаргаагүй.<br><br>Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнийг авч ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд холбогдох төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэхэд шаардагдах зардлыг 2019, 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөлд тусган санал өгсөн боловч эрх бүхий байгууллага батлаагүй**.** | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | Хэрэгжих шаардлага тай төсөв батлагдах-гүй байгаа тул цаашид хяналтаас хасах саналтай. |
| 29 | 46 | **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв байгуулах тухай**<br><br>2019-04-03, № 125<br><br>2.5. Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын 2016 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн хэлэлцээрийн дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв барих” төслийн хүрээнд бий | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br><br>“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв барих” төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн өмчид бүртгэх ажил хийгдэж байна.<br><br>Эхний ээлжинд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төв” нь хандив, тусламж, бэлэглэл, төслийн шугамаар бий болсон хөдлөх хөрөнгийг бүртгэлд тусгасан байна.<br><br>Барилгыг улсын комисс хүлээн аваагүй байгаа тул төрийн өмчид бүртгэх ажил хийгдээгүй хүлээгдэж байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | болсон хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн өмчид бүртгэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т. | | | |
| 30 | 47 | **Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2019-04-17, № 149<br>3.Иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зарчмыг баримтлан технологийн дэвшлийг ашиглаж төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд хандан авах замаар шийдвэрлэх, “Үйлчилгээний нэгдсэн төв”-д ажиллах байгууллагын албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, Шүүхийн ерөнхий зөвлөл (Н.Лүндэндорж)-д зөвлөсүгэй. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>“ХУР” системтэй мэдээлэл солилцох тухай гэрээг 2018 онд байгуулан худалдан авах ажиллагаанд шаардлагатай мэдээллийг төрийн бусад байгууллагаас шуурхай авч ашигласан. Төрийн худалдан авах ажиллагааны чиг үүрэг шинээр байгуулагдсан агентлагт шилжсэн.<br>Төрийн өмчийн асуудлаар иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх ямар үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх боломжтой талаар болон төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг үйлчлүүлэгчээс шаардахгүйгээр төрийн мэдээллийн сантай холбогдон авах боломжийг судалж байна. Энэ асуудлыг Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн сангийн програм хангамжийг сайжруулан боловсруулах, нэгдсэн мэдээллийн сан бий болгох, төрийн бусад мэдээллийн сантай холбох арга хэмжээг авч хэрэгжүүлэх санал боловсруулах хүрээнд судалж байгаа.<br>Одоогоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эрхэлж байгаа үйл ажиллагааны хүрээнд “Үйлчилгээний нэгдсэн төв”-д албан хаагчийг ажиллуулах шаардлагагүй. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| 31 | 48 | **Монгол-Хятадын хамтарсан компани байгуулах тухай**<br>2019-04-23, № 164<br>3. Монгол-Хятадын хамтарсан компани байгуулах гэрээ, компанийн дүрмийн хэрэгжилтийг хагас жил тутам Зам, тээврийн хөгжлийн яаманд тайлагнахыг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Р.Мэргэн), “Монголиан порт групп” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Цэнгэл)-д үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Монгол-Хятадын хамтарсан компани байгуулах гэрээ, компанийн дүрмийн хэрэгжилтийг хагас жил тутам Зам, тээврийн хөгжлийн яаманд тайлагнаж байх талаар “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд удирдамж, чиглэл өгсөн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэвшсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 32 | 49 | **Төрийн өмчит үйлдвэрийн газрын талаар авах зарим арга хэмжээний тухай** | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Биокомбинат” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн | “Бүрэн хэрэгжсэн” – | Засгийн газраас |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2019-05-01, № 186<br>2.”Биокомбинат” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, төсвийг баталж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгасугай. | газрыг Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 237 дугаар тогтоолоор “Биокомбинат” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн зохион байгуулж, хувьцаа эзэмшигчийн эрхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. | 100%. | дараагийн арга хэмжээ авсан шийдвэр гарсан тул хяналтаас хасах саналтай. |
| | 50 | **Төрийн өмчит үйлдвэрийн газрын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2019-05-01, № 186<br>3.”Биокомбинат” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг байгуулсантай холбогдуулан гүйцэтгэх удирдлагыг мэргэжлийн багаар гүйцэтгүүлэн ажиллуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Биокомбинат” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 237 дугаар тогтоолоор “Биокомбинат” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн зохион байгуулж, хувьцаа эзэмшигчийн эрхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100%. | Засгийн газраас дараагийн арга хэмжээ авсан шийдвэр гарсан тул хяналтаас хасах саналтай. |
| 33 | 51 | **Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай**<br>2019-07-03, № 276<br>3.Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоосонтой холбогдон гарч болзошгүй нэмэлт зардлыг 2019 оны хувьд батлагдсан төсөвт багтааж, цаашид жил бүрийн улсын төсвийн төсөлд тооцон тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Агентлаг байгуулах тухай” 438 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэг өөрчлөгдөж, Ерөнхий сайдын 2020 оны 06 дугаар захирамжаар байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэн батлагдсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн үйлчилгээний 3 албан хаагчтай ажиллаж байгаа бөгөөд эдгээр албан хаагчдын албан тушаалын зэрэглэлийг энэхүү тогтоолоор тогтоож, албан тушаалын тодорхойлолтод тусган баталсан. Цалин хөлсийг тухайн албан тушаалын зэрэглэлд хамааруулан хууль тогтоомжид заасны дагуу тогтоон олгож байна. 2 албан хаагч төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, 1 албан хаагч мэргэшлийн зэргийн нэмэгдлийг авч байгаа бөгөөд холбогдох цалин хөлс, нэмэгдлийн зардлыг тухай бүр улсын төсөвт тусгаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэвшиж тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай. |
| 34 | 52 | **“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай** | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>2.1.“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 28 дугаар тогтоолоор “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компани “Эрдэнэс- | “Хэрэгжих шатанд” – 70% | Засгийн газрын 2020 оны |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2019.07.09, № 296<br><br>2. Тавантолгой нүүрсний ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцааг зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад улсын хөрөнгийн биржээр арилжаалахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т тус тус даалгасугай: 2.1. Олон улсын хөрөнгийн зах зээлээс боломжит богино хугацаанд хамгийн бага зардлаар хөрөнгө босгох зорилгоор холбогдох хууль тогтоомж, олон улсын стандарт, шаардлагад нийцүүлэн “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компаниудыг байгуулах; 2.2. Тавантолгой нүүрсний ордын үнэ цэнийг цаашид үе шаттайгаар нэмэгдүүлэх зорилгоор “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн эзэмшлийн тусгай зөвшөөрлүүдээс эхний ээлжинд MY-011943 дугаар бүхий Цанхийн зүүн хэсгийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компанид эзэмшүүлэх; 2.3. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компанийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад улсын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгө оруулагчдад санал болгох, 70 буюу түүнээс доошгүй хувийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК эзэмшиж байхаар зохион байгуулах; 2.4. Гадаад улсын хөрөнгийн биржээр хувьцаа арилжаалах үйл ажиллагааг богино хугацаанд зохион байгуулах, түүнтэй холбогдсон татвар, зардлын хэмжээг хамгийн бага байлгах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллах. | Тавантолгой Майнинг” ХХК-ийг үүсгэн байгуулсан.<br><br>2.2.“Эрдэнэс-Тавантолгой” ТУЗ-ийн 2019 оны 54 дүгээр тогтоолоор "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн эзэмшлийн Цанхийн зүүн хэсгийн MY-011943 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийг "Эрдэнэс-Тавантолгой Майнинг" ХХК-д хөрөнгө оруулалт хэлбэрээр шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Тус ТУЗ-ийн тогтоолын дагуу уг тусгай зөвшөөрлийг шилжүүлэх тухай хүсэлтийг Ашигт малтмал, газрын тосны газар ("АМГТГ")-т гаргасны дагуу АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2019 оны 533 дугаар шийдвэрээр MY-011943 дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг "Эрдэнэс-Тавантолгой Майнинг" ХХК-д шилжүүлсэн.<br><br>2.3.“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн охин компани “Эрдэнэс-Тавантолгой Майнинг” ХХК нь хувьцааныхаа 30 хүртэлх хувийг гадаад улсын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгө оруулагчдад санал болгохоор бэлтгэл ажлыг ханган, гадны зөвлөх үйлчилгээг аван ажиллаж байсан боловч 2020 оны 01 сараас дэлхий дахинд үүссэн цар тахлын улмаас гүйцэтгэл хүлээгдэж байгаа болно.<br><br>2.4.Хувьцааг гадаад улсын хөрөнгийн биржээр арилжаалахтай холбогдон ерөнхий мэдээлэл авах зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн холбогдох албан тушаалтнууд 2019 онд Лондон, Хонконгийн хөрөнгийн биржийн удирдлагуудтай уулзалт хийсэн бөгөөд хөрөнгийн биржид арилжаа эхлүүлэхэд шаардагдах бэлтгэл ажлын талаар мэдээлэл аван ажилласан. | | 146 дугаар тогтоолоор энэ тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгон шийдвэр-лэсэн.<br><br>Хяналтаас хасах саналтай. |
| | 53 | **“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай** | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Засгийн газрын 2019 оны 296 дугаар тогтоолоор даалгасан үүргийг | “Хэрэгжих шатанд” – 70% | Засгийн газрын 2020 оны |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2019.07.09, № 296<br><br>4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явц байдлыг Засгийн газар, Улсын Их Хуралд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т тус тус үүрэг болгосугай. | хэрэгжүүлэхэд анхаарч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тухай бүр хэрэгжилтэд хяналт тавьж, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой санал хүргүүлэн, хэрэгжилтийг хянан ажилласан. | | 146 дугаар тогтоолоор энэ тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгон шийдвэр-лэсэн. |
| 35 | 54 | **Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br><br>2019-07-24, № 304<br><br>1. Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 242 дугаар тогтоолоор байгуулагдсан “Тавантолгой төмөр зам” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцааны 66 хувийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д тус тус эзэмшүүлэх, холбогдох журмын дагуу бүртгүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>2019 оны 08 сарын 16-ны өдөр хуралдсан "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн шинэчилсэн дүрмийг баталсан. 2019 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн "Тавантолгой төмөр зам" ХХК -ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 03 дугаар тогтоолоор "Тавантолгой төмөр зам" ХХК -ийн 66 хувийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д, 34 хувийг "Монголын төмөр зам" ТӨХК-д тус тус эзэмшүүлэх хувьцаа эзэмшигчдийн гэрээг байгуулсан. Холбогдох журмын дагуу хувьцааг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| | 55 | **Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br><br>2019-07-24, № 304<br><br>2. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, ашиглахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг техник, эдийн засгийн үндэслэлд заасан дүнгээр нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ авахыг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баяраа)-д | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Төслийн үйл ажиллагааг цаг алдалгүй эхлүүлэх зорилгоор “Тавантолгой төмөр зам” ХХК-д санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-иас төслийн санхүүжилтийг шийдвэрлэхээр ажиллаж, “Монголын төмөр зам” ТӨХК-тай 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн ЭТТ-2019/351 дугаар бүхий Төслийн санхүүжилтийн урьдчилгаа төлбөр олгох гэрээг байгуулсан.<br><br>Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах, ашиглахад шаардагдах хөрөнгийг техник, эдийн засгийн үндэслэлд заасан дүнгээр нүүрс урьдчилан борлуулах замаар болон бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх арга хэмжээ аван | “Хэрэгжих шатанд” - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | зөвшөөрч, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (А.Ариунболд)-т даалгасугай. | хэрэгжүүлж байна. | | |
| 36 | 56 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай**<br>2019-12-11, № 422<br>2. Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Тогтоолыг Шинжлэх ухааны академийн Палеонтологийн хүрээлэн, Баянзүрх дүүргийн Прокурорын газар, ХААҮШУОНТөв, ХХААХҮЯ-нд тус тус хүргүүлж, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгуулах арга хэмжээ авсан. Барилгыг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүлээлцсэн бөгөөд тогтоолын биелэлтийн тайланг Палеонтологийн хүрээлэнгээс 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/79 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.<br>ШУА-ийн харьяа Палеонтологи, геологийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 10.1 сая төгрөгийн агуулахын барилгыг Баянзүрх дүүргийн Прокурорын газар хүлээн авч санхүүгийн тайлан балансандаа тусгасан. ХААҮШУОНТ УТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 675.1 сая төгрөгийн балансын үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүлээн авч, 2020 оны санхүүгийн тайлан балансандаа тусгасан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Бүрэн хэрэгжиж дууссан тул хяналтаас хасах саналтай. |
| 37 | 57 | **Агентлаг байгуулах тухай**<br>2019-12-18, № 438<br>3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Төрийн худалдан авах ажиллагааны газарт чиг үүрэг нь шилжиж байгаа орон тоог холбогдох ажилтан, үйл ажиллагааны зардал, цалингийн сан, эд хөрөнгийн хамт шилжүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ЗУХ, ТӨБАХ**<br>ТӨБЗГ-ын даргын 2020 оны А/06 дугаар тушаалаар ТӨБЗГ-ын бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан “Төрийн худалдан авах ажиллагааны газарт чиг үүрэг нь шилжсэн 37 албан хаагчийн холбогдох баримт бичиг, эд хөрөнгийг шилжүүлэн хүлээлцэж, төрийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулан ажиллуулсан.<br>Орон тоог холбогдох ажилтан, үйл ажиллагааны зардал, цалингийн сангийн хамт шилжүүлсэн.<br>Хөрөнгийн тооллого, тулгалт хийж, хөрөнгийг үе шаттай шилжүүлж байна. ТӨБЗГ-ын 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 101 дүгээр тогтоолоор тээврийн хэрэгслийг шилжүүлсэн. ТӨБЗГ-ын 2020-12 дугаар сарын 17-ны өдрийн 693 дугаар тогтоолоор ТӨБЗГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1.8 тэрбум хөрөнгийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Бүрэн хэрэгжиж дууссан тул хяналтаас хасах саналтай. |
| 38 | 58 | **Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого** | **ТӨБЗГ – ТӨБАХ** | “Хэрэгжих | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **явуулах тухай**<br>2020-01-08, № 9<br>1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангийн дүнгээр тасалбар болгон явуулж, дүнг 2020 оны IY улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгасугай. | Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогод ашиглах төрийн өмчийн бүртгэлийн болон захиргааны статистикийн маягтуудыг шинэчлэн батлуулах асуудлыг боловсруулж, Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/33 дугаар тушаалаар ТӨБЗГ-т маягтыг баталж, мөрдүүлэх тухай зөвшөөрөл авсан. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/70 дугаар тушаалаар өмнө мөрдөж байсан маягтуудыг хүчингүй болгуулах асуудлыг шийдвэрлүүлсэн. Шинэчлэн боловсруулсан маягтуудыг батлуулахаар ТӨБЗГ-ын хуралдаанд оруулахаар бэлтгэл хангаад байна.<br>Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор тооллогын ажлыг хойшлуулах санал бүхий Засгийн газрын тогтоолын төслийг танилцуулгын хамт бэлтгэн ТӨБЗГ-ын 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А-1/983 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 42 дугаар тогтоолоор энэхүү тогтоолд өөрчлөлт оруулж, улсын үзлэг, тооллогыг 2021 онд зохион байгуулахаар шийдвэрлэсэн.<br>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт улсын үзлэг тооллогыг 2021 онд зохион байгуулах асуудлыг тусгасан боловч 2021 оны төсөвт зардлын асуудал тусгагдан батлагдаагүй.<br>Засгийн газрын тогтоолд орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан удирдамж, Үндэсний статистикийн хорооноос баталсан маягт, асуулгын дагуу зохион байгуулж, дүнг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ТӨБЗГ-т хүргүүлэх талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасны дагуу 2021 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган Газар зохион байгуулалт, барилга, хот байгуулалтын газар, хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг байгууллагатай уялдаатай ажиллах, улсын үзлэг, тооллогын ажлын бэлтгэл хангах зөвлөмж хүргүүлэх тухай албан бичгийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлээд байна.<br>Тогтоол хэрэгжүүлэх хугацааг Засгийн газрын 2020 оны 42 дугаар тогтоолоор хойшлуулсан. | шатанд” – 70%. | |
| 39 | 59 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-01-08, №10 | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарт ТӨБЗГ-ын даргын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А-1/268, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, орон нутгийн өмчийн байгууллагад 2020 оны 03 | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хариуцла-гын асуудлыг шийдвэр-лүүлэх |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг батлагдсан аргачлалын дагуу үнэлээгүй, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлээгүй хуулийн этгээдийн удирдлагад зохих журмын дагуу хариуцлага тооцохыг төсвийн ерөнхийлөн захирагч нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т тус тус даалгасугай. | дугаар сарын 03-ны өдрийн А-1/269 дүгээр албан бичгээр Засгийн газрын 10 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөмж чиглэл хүргүүлсэн.<br>Сайд нарт үнэлгээний ажлын дүнг танилцуулах арга хэмжээ авч, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлээгүй байгууллагын жагсаалтыг хүргүүлэн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох ажлыг зохион байгуулсан. Энэ хүрээнд, Засгийн газрын шийдвэрээр 2018 онд хийгдсэн дахин үнэлгээнд хамрагдаагүй үл хөдлөх хөрөнгө, үнэлгээ хийгдээгүй орхисон газар эзэмших эрхийг үнэлж, 2019 оны санхүүгийн тайланд тусгаагүй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох асуудлаар яамдын төрийн нарийн бичгийн дарга нар, УИХ-ын харьяа төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт А-1/272 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлсэн. | | арга хэмжээ авсан, хяналтаас хасах саналтай байна. |
| | 60 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-01-08, №10<br>3. Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай үнэлэгдсэн барилга байгууламжийн үнэлгээ, төсвийн зардал, чанар байдлыг нягтлан үзэж, шаардлагатай тохиолдолд залруулах, зөрчил гаргасан албан тушаалтанд зохих журмын дагуу хариуцлага тооцохыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Төсвийн ерөнхийлөн захирагч нарт ТӨБЗГ-ын 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А-1/269 дүгээр албан бичгээр Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх чиглэл өгч, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлээгүй байгууллагын жагсаалтыг хүргүүлэн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох ажлыг зохион байгуулсан.<br>Үнэ цэнийн бууралттай үнэлэгдсэн зарим барилгын үнэлгээг дахин нягтлах, залруулахын тулд үнэлгээчээр дахин хянуулах ажлыг зөрчил гаргасан тухайн байгууллага хариуцан хийж, 2020 оны санхүүгийн тайланд залруулга хийж, бүртгэх талаар Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл өгсний дагуу холбогдох саналаа тухай бүр ТӨБЗГ-т ирүүлэн шийдвэрлүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| | 61 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-01-08, № 10<br>4. Үнэлгээнд хамрагдаагүй газар эзэмших, ашиглах эрх, дахин үнэлгээ хийгдээгүй үл хөдлөх хөрөнгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлалын дагуу үнэлж, 2020 оны санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулахыг Сангийн сайд | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан аргачлалыг ашиглан газар эзэмших, ашиглах эрхийг 2020 онд багтаан үнэлж, жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгах асуудлаар чиглэл авахаар Сангийн яаманд 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А-1/270 дугаар албан бичиг хүргүүлсэн.<br>Үнэлээгүй үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших эрхийн судалгааг гарган, үнэлгээ хийхэд бэлэн болгосон.<br>Үүний дүнд, Сангийн сайдын 2020 оны 6 дугаар сарын 29-ний | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгасугай. | өдрийн 7/4446 дугаар албан бичгээр газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээнд Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалыг ашиглах чиглэл ирүүлсэн. Уг чиглэлийн дагуу 2018 онд хийгдсэн дахин үнэлгээний ажлын явцад дахин үнэлгээ хийгдээгүй үл хөдлөх хөрөнгө, үнэлгээ хийгдээгүй орхисон газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж 2020 оны санхүүгийн тайланд тусгахыг нийслэл, 21 аймгийн Засаг дарга нар, Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газарт тус тус 2020 оны А-1/1113 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үнэлгээг журам, зааврын дагуу хийж, 2020 оны санхүүгийн тайланд тусгах арга хэмжээг авч ажилласан. | | |
| | 62 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-01-08, №10<br>6. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд олгосон газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, төрийн өмчийн бүртгэлд тусгаж байхыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан), Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Сангийн яамнаас 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 7/1403 дугаартай албан бичгээр үнэлгээний аргачлалыг дахин боловсруулах чиглэлийг ирүүлсэн. Аргачлалыг дахин боловсруулах зардал, хугацаа байхгүй тул 2018 оны дахин үнэлгээний аргачлалыг хэрэглэх саналаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А-1/725 дугаар албан бичгээр Сангийн сайдад хүргүүлэв.<br>Сангийн сайдын 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 7/4446 дугаар албан бичгээр газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээнд Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалыг ашиглах чиглэл ирүүлсэн тул 2018 оноос 2020 онд шинээр олж авсан газар эзэмших, ашиглах эрхийг дээр дурдсан аргачлалын дагуу нөхөн үнэлж, нягтлан шалгалтын үнэлгээчнээр баталгаажуулан, дүнг 2020 оны санхүүгийн тайланд тусгах чиглэлийг ТӨБЗГ-аас нийслэл, 21 аймгийн Засаг дарга нар, Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газарт тус тус хүргүүлсэн. Үнэлгээ хийж бүртгэлд тусгах ажил тухай бүр хийгдэж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| | 63 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-01-08, №10<br>8. Төрийн өмчит хуулийн этгээдэд олгосон газар эзэмших эрхийн зориулалтыг өөрчлөх, төрийн өмчит хуулийн этгээд хооронд хуваах, шилжүүлэн эзэмшүүлэх | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Аймаг, нийслэлийн Засаг дарга нар, аймгийн Орон нутгийн өмчийн газар, нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А-1/269 дүгээр албан бичгээр Засгийн газрын 10 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах талаар чиглэл, зөвлөмж хүргүүлсэн.<br>Төрийн өмчит хуулийн этгээдээс газрын зориулалтыг өөрчлөх | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэвшиж байгаа тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | асуудлыг тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн хамт шийдвэрлэх саналыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлж байхыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгасугай. | асуудлаар ирүүлсэн саналыг тухай бүр шийдвэрлэн хүргүүлж байна. Тухайлбал, ХЗДХЯ-ны эзэмшлийн 524 м.кв газрыг Монголбанкинд шилжүүлэх зөвшөөрлийг шийдвэрлэж, 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А-1/121 дүгээр албан бичгээр хүргүүлсэн байна.<br>Газар эзэмших эрхийг шилжүүлэх, зориулалт өөрчлөх асуудлыг ТӨБЗГ-ын хуралдаанд оруулж, хэлэлцүүлэн шийдвэрлүүлж байгаа болно.<br>Төрийн өмчит хуулийн этгээдэд олгосон газар эзэмших эрхийн зориулалтыг өөрчлөх, төрийн өмчит хуулийн этгээд хооронд хуваах, шилжүүлэн эзэмшүүлэх асуудлыг тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн хамт шийдвэрлэхдээ аймаг, нийслэлийн Засаг дарга нарын саналыг албан ёсоор авч тусгаж байгаа болно. | | |
| | 64 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-01-08, № 10<br>10. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сангийн програм хангамжийг боловсруулах, нэгдсэн мэдээллийн сан бий болгох, төрийн бусад мэдээллийн сантай холбох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн сангийн програм хангамжийг сайжруулан боловсруулах, нэгдсэн мэдээллийн сан бий болгох, төрийн бусад мэдээллийн сантай холбох арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр санал, төсвийн урьдчилсан тооцоог бэлтгэж, Монгол Улсын 2021 оны төсөвт тусгуулах арга хэмжээ авсан боловч улсын төсөвт шаардлагатай хөрөнгийн асуудал тусгагдаагүй байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд уг асуудал тусгагдсан болно. Шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх асуудлын хувилбарыг судалж байна. Төрийн өмчийн бүртгэлийн системийн программ хангамжийн асуудалтай холбоотойгоор урьдчилсан байдлаар газар, үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл оруулах программыг шийдвэрлэх, шинээр бий болгох программ хангамжийн төсөл боловсруулахаар бэлтгэж байна. | “Хэрэгжээгүй” - 0 | |
| 40 | 65 | **Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ажлын алба байгуулах, орон тооны хязгаарыг батлах тухай**<br>2020-01-08, №16<br>3. Тариаланг дэмжих сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгө, өглөг, авлага болон Мал хамгаалах сангаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 7-ны өдрийн А/49 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл ажилласан. Уг ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны А/134 дүгээр тушаалаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 22.7 сая төгрөгийн бараа материал, 22.0 сая төгрөгийн авлагыг Хөдөө аж ахуйг дэмжих санд | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд шилжүүлсэн хөрөнгө, өглөг, авлагыг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу Хөдөө аж ахуйг дэмжих санд шилжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгасугай. | шилжүүлсэн.<br>Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг Хөдөө аж ахуйг дэмжих санд шилжүүлэх асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А-1/1159 дүгээр албан бичгээр шийдвэрлэсэн.<br>Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн нэр нь өөрчлөгдөж Хөдөө аж ахуйг дэмжих сан болсон учир үндсэн хөрөнгөтэй холбоотой шийдвэр гараагүй болно. Бусад өр авлага, эргэлтийн хөрөнгийн асуудлыг ХХААХҮЯам шийдвэрлэсэн болно. | | |
| 41 | 66 | **Жагсаалт батлах тухай**<br>2020-01-22, № 21<br>3.Худалдан авах ажиллагааг (tender.gov.mn) цахим системээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүн, гэрээг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Агентлаг байгуулах тухай” 438 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэгт хамаарч байсан Төрийн худалдан авах ажиллагааны чиг үүрэг шинээр байгуулагдсан Засгийн газрын агентлаг болох Төрийн худалданавах ажиллагааны газарт шилжсэн. Засгийн газрын 2019 оны 438 дугаар тогтоолыг үндэслэн Ерөнхий сайдын 2020 оны 06 дугаар захирамжаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц” шинэчлэгдэн батлагдсан.<br>2020 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь өөрийн байгууллагын хэрэгцээнд шаардлагатай барааны 3 худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан бөгөөд 2 нь нээлттэй сонгон шалгаруулалтын журмаар, уламжлалт аргаар, 1 нь шууд худалдан авалт байна. 2020 оны төсвийн жилд зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны холбогдох төлөвлөгөө, зар мэдээлэл, тайланг ил тод, нээлттэй мэдээлэх арга хэмжээ авсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хяналтаас хасах саналтай. |
| 42 | 67 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай**<br>2020-02-12, № 54<br>2. Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах талаар Өвөрхангай аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал, хэмжил зүйн хэлтэст 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А-1/466 дугаар албан бичгийг хүргүүлж, шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээ авч ажиллав.<br>Өвөрхангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 76,412,420.00 төгрөгийн балансын үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэст балансаас балансад шилжүүлэн авч 2020 оны санхүүгийн тайлан | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | балансанд тусгасан. | | |
| 43 | 68 | **Орон сууц хувьчлах тухай**<br>2020-02-12, № 56<br>2. Албан тушаалын орон сууцнуудыг ашиглаж байгаа оршин суугчдад хөнгөлөлттэй үнээр худалдан шилжүүлэх болон хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ, ТӨУЗХ**<br>Батлан хамгаалах сайдын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/76 дугаар тушаалаар “Албан тушаалын орон сууцыг ашиглаж буй оршин суугчдад нь хөнгөлөлттэй үнээр худалдан шилжүүлэх болон хувьчлах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг” байгуулсан бөгөөд ТӨБЗГ-ын төлөөлөл уг ажлын хэсэгт ажиллаж байна. Ажлын хэсэг нийт 7 удаа хуралдаж, гаргасан шийдвэрийн дагуу Батлан хамгаалахын сайдын 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/82 дугаар тушаалаар “Албан тушаалын орон сууц хувьчлах журам”-ыг, мөн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/95 дугаар тушаалаар “Албан тушаалын орон сууцны хөнгөлөлттэй үнэ тогтоох тухай” асуудлыг тус тус баталсан байна.<br>Одоогийн байдлаар, БХЯ-ны эзэмшлийн хөнгөлөлттэй үнээр худалдан шилжүүлэх 563 айлын орон сууцнаас 411 оршин суугчдад нь байрны төлбөр төлөх тухай мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд 210 гаруй айл төлбөрөө тодорхой хэмжээгээр төлөөд байна. Үлдсэн 150 орчим оршин суугчийн асуудлыг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 44 | 69 | **Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай**<br>2020-02-12, № 62<br>3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ЗУХ, Шуурхай штаб**<br>Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэнтэй холбогдуулан гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангуулах чиг үүрэг бүхий Шуурхай штабыг ТӨБЗГ-ын даргын 2020 оны А/09 дүгээр тушаалаар байгуулж, ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Шуурхай штабыг газрын даргын 2020 оны А/74 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулж ажиллуулсан.<br>Мөн ТӨБЗГ-ын даргын 2020 оны “Шинэ коронавируст халдварын эрсдэлээс сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” А/19 дүгээр тушаал гарган хорио цээрийн дэглэм, хэм хэмжээг чанд сахиж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгож, халдварын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх онцгой нөхцөл байдлын үед байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, төрийн үйлчилгээг иргэд, үйлчлүүлэгчдэд чирэгдэлгүй шуурхай хүргэх ажлыг оновчтой зохион байгуулахыг хэлтэс, албадын дарга нарт даалган нэгдсэн удирдлагаар ханган ажиллав.<br>Байгууллагын Шуурхай штабаас эрсдэлээс урьдчилан сэргийлэх, | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэвшиж тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | халдвар, хамгааллын горим, дэглэмийг сахих талаар талаар тодорхой арга хэмжээ аван ажиллаж байна. Тухайлбал, албан хаагчдыг гар ариутгагч, амны хаалт, дархлаа дэмжих бэлдмэлээр хангаж, харуул хамгаалалтын ажилтнуудыг халдваргүйжүүлэх бодис, бээлий, амны хаалт, халуун хэмжигч зэрэг халдвараас хамгаалах хэрэгслээр хангав. Албан хаагчдын ажлын горимд зохих өөрчлөлт оруулж, 0-12 насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн гэрээсээ цахимаар ажиллах нөхцлийг хангаж, хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн.<br><br>Засгийн газар, Улсын онцгой комисс, Төрийн албаны зөвлөл, мэргэжлийн бусад байгууллагуудаас гаргасан зөвлөмж, санамжийг сурталчлан таниулах, болзошгүй эрсдэлээс хамгаалах арга хэмжээг авсан. Энэ талаар харьяа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд чиглэл өгөн ажилласан. | | |
| 45 | 70 | **Төлөвлөгөө батлах тухай**<br><br>2020-02-19, № 66<br><br>1.“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын төлөвлөгөө”-г хавсралт ёсоор батлалсугай.<br><br>2.Төлөвлөгөөнд тусгагдсан хуулийг тогтоосон хуваарийн дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгасугай. | **ТӨБЗГ – ХЭЗХ**<br><br>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 174 дүгээр тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэлтсийн дарга нар ажиллаж байна. Ажлын хэсэг БНСУ, Казкастан, Истон зэрэг бусад орны хуулийг судалж үзсэний үндсэн дээр хуулийн үзэл баримтлалыг боловсруулж дууссан бөгөөд үзэл баримтлалд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас санал авах тухай хүсэлтийг 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А-1/2165 дугаартай албан бичгээр хүргүүлээд байна.<br><br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “төрийн нийтийн өмч”-ийг Үндсэн хуулийн 6.2-т нийцүүлэн тодорхойлж, өмчлөгч нь бүх ард түмнийг төлөөлж, УИХ байх зохицуулалтыг оруулна гэж хуулийн үзэл баримтлалд тусгасан болно.<br><br>УИХ-ын 2020 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад эдгээр хуулийн төсөл тусгагдсан. Коронавируст цар тахалтай тэмцэх, сэргийлэх арга хэмжээний улмаас гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотойгоор ажлын хэсэг цуглаж, хуралдах боломжгүй нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор онлайнаар хуралдаж, хуулийн төслийн 1-3 дугаар бүлгийг бичиж эхлээд байна. | “Хэрэгжих шатанд” – 70 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 46 | 71 | **“Амгалан дулааны станц” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн талаар авах арга хэмжээний тухай**<br>2020-02-19, № 71<br>3.Өөрчлөн зохион байгуулагдсан компанийн үйл ажиллагааг хэвийн, найдвартай явуулахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Амгалан дулааны станц ХХК-ийг бие даасан төрийн өмчит хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулж, компанийн дүрмийг батлан улсын бүртгэлд бүртгүүлсэн. Мөн компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирлыг томилж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Компанийн удирдах бүрэлдэхүүнийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажилласан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 47 | 72 | **Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-02-28, № 78<br>8. Энэ онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан шуурхай зохион байгуулж, мэдээллийг ил тод нийтэлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>2020 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь өөрийн байгууллагын хэрэгцээнд шаардлагатай барааны 3 худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан бөгөөд 2 нь нээлттэй сонгон шалгаруулалтын журмаар, уламжлалт аргаар, 1 нь шууд худалдан авалт байна. 2020 оны төсвийн жилд зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны холбогдох төлөвлөгөө, зар мэдээлэл, тайланг ил тод, нээлттэй мэдээлэх арга хэмжээ авсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 48 | 73 | **Эрүүл мэндийн сургалт, эрдэм шинжилгээний зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай**<br>2020-03-18, № 98<br>7. Шилжиж байгаа байгууллагын үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Эрүүл мэндийн сайдын багцаас Анагаах ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлж, харьяалал өөрчлөгдсөн бөгөөд байгууллагын хөрөнгөд хөдөлгөөн хийх шаардлагагүй тул ТӨБЗГ-аас шийдвэр гаргахгүй болно.<br>Төрийн өмчийн бүртгэлд тус байгууллагын санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө бүрэн бүртгэгдсэн байгаа. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 49 | 74 | **Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай**<br>2020-03-22, № 102<br>4. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ажлын байр, орон сууц болон өрөө, тасалгаанд ариутгал халдваргүйтгэл хийх арга хэмжээг улсын хэмжээнд 14 хоногийн хугацаанд багтаан зохион байгуулахыг нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд даалгасугай. | **ТӨБЗГ – ЗУХ, Шуурхай штаб**<br>ТӨБЗГ-ын даргын 2020 оны А/09 дүгээр тушаалаар байгуулагдсан Шуурхай штабын зүгээс ажлын байрны ариутгал халдваргүйтгэл хийж, халдварт эрсдэлээс урьдчилан сэргийлэх, халдвар, хамгааллын горим, дэглэмийг сахих талаар талаар тодорхой арга хэмжээ аван ажиллаж байна. Тухайлбал, албан хаагчдыг гар ариутгагч, амны хаалт, дархлаа дэмжих бэлдмэлээр хангаж, харуул хамгаалалтын ажилтнуудыг халдваргүйжүүлэх бодис, бээлий, амны хаалт, халуун хэмжигч зэрэг халдвараас хамгаалах хэрэгслээр хангав. 2020 онд энэ төрлийн арга хэмжээнд нийт 6.5 сая төгрөгийн төсвийг зарцуулсан байна.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Засгийн газрын 9-р байранд байршилтай тул Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний шугамаар нийтийн эзэмшлийн гудамж, талбайн ариутгал халдваргүйжүүлэлтийг мөн хийж байгаа болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжиж тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай. |
| 50 | 75 | **Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-03-25, № 106<br>1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” үр дүнтэй болсныг тэмдэглэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг яам, Засгийн газрын агентлаг, байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Тогтоолын заалтаар өгсөн үүрэг даалгавар, улсын үзлэгийн комиссын дүгнэлтийг хэрэгжүүлэх ажлыг байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Улсын үзлэгийн мөрөөр авах арга хэмжээг судлан тодорхойлох, холбогдох албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэх ажлыг нарийвчлан тусгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>Мөн тайлант хугацаанд хууль зүйн алдаатай холбогдох тушаалуудыг хүчингүй болгох, Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам, Сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлах, төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах асуудлын хүрээнд Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэгтэй гэрээ хийж, албан хаагчдыг эмнэлгийн үзлэг, оношилгоо, үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авах, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг эрх нь үүссэн төрийн захиргааны 5, төрийн үйлчилгээний 2 албан хаагчид, төрийн захиргааны 4 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг шинээр болон нэмэгдүүлэн олгох, албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулан Төрийн албаны зөвлөлд хянуулан зөвшөөрөл авч, батлах зэрэг ажлыг хийж гүйцэтгэв. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| | 76 | **Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай** | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Улсын үзлэгийн мөрөөр хэрэгжүүлэх ажлыг байгууллагын 2020 оны | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2020-03-25, № 106<br>2. Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч нарт үүрэг болгосугай. | гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан бөгөөд хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021 оны төсвийн төсөлд шаардлагатай хөрөнгийг тусгах талаар судалгаа, тооцоо хийж, тусгах арга хэмжээ авсан боловч холбогдох байгууллагаас батлаагүй байна. | ХБ. | |
| 51 | 77 | **“Боловсролын мэдээллийн технологийн төв” байгуулах тухай**<br>2020-03-25, № 111<br>2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй “Боловсролын салбарын мэдээллийн систем”-ийн болон “Эрдэмнэт” сүлжээний төвийн мэдээллийн технологийн холбогдох тоног төхөөрөмж, эд хөрөнгийг “Боловсролын мэдээллийн технологийн төв”-д балансаас балансад холбогдох хууль, журмын дагуу шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан) нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/207 дугаар тушаалаар “Боловсролын салбарын мэдээллийн систем” болон ШУТИС-ийн дэргэдэх “Эрдэмнэт” сүлжээний төвийн хөрөнгөд бүртгэлтэй үндсэн болон эргэлтийн хөрөнгийг “Боловсролын мэдээллийн технологийн төв”-д балансаас балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Дээрх ажлын хүрээнд Улаанбаатар хот дахь холбооны шугам сүлжээний 6 цэг, Боловсролын дата төв, “Боловсролын мэдээллийн систем”-ийн болон “Эрдэмнэт” сүлжээний төвийн хөрөнгийн тооллогыг тус тус гүйцэтгэсэн.<br>ТӨБЗГ-ын 2020 оны 510 дугаар тогтоолоор БШУЯ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 122 нэрийн 8.5 тэрбумын балансын үнэ бүхий хөрөнгө, ТӨБЗГ-ын 549 дүгээр тогтоолоор "Эрдэмнэт сүлжээний төв"-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 41 нэрийн 226.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг “Боловсролын мэдээллийн технологийн төв”-д балансаас балансад тус тус шилжүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 52 | 78 | **Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-03-27, № 114<br>3.2. Төсвийн урсгал зардлаас дараахь зардлыг тэргүүн ээлжид санхүүжүүлэх:<br>3.2.1. бүх шатны эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны зардал; | **ТӨБЗГ – ЗУХ**<br>ТӨБЗГ-ын 2020 оны үйл ажиллагааны зардалд төсвийн тодотголын дүн орсноор нийт 1,254.7 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд энэ тогтоолд заасан зардлыг санхүүжүүлсэн байна. Тухайлбал, коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахтай холбоотой бүх төрлийн зардалд 6.5 сая төгрөгийн төсвийг зарцуулсан байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 3.2.2.бүх шатны төсвийн байгууллагын коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахтай холбоотой бүх төрлийн зардал;<br>3.2.3.бүх шатны төсвийн байгууллагын цалин хөлс, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай зардал;<br>3.2.4.нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ. | | | |
| | 79 | **Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-03-27, № 114<br>3.4.Төсвийн урсгал зардлаас дараахь зардлын санхүүжилтийг түр зогсоох:<br>3.4.1.бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, сургалт семинар зохион байгуулах, тавилга эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх;<br>3.4.2.хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал;<br>3.4.3.цалин хөлснөөс бусад бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр;<br>3.4.4.бараа үйлчилгээний бусад зардал. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>ТӨБЗГ-ын 2020 оны үйл ажиллагааны зардалд төсвийн тодотголын дүн орсноор нийт 1,254.7 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд энэ тогтоолын 3.4 дэх хэсэгт заасан зардлыг Сангийн яамны хяналтад зогсоосон байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 53 | 80 | **“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын талаар авах зарим арга хэмжээний тухай** | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын 2016-2019 оны үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2020-04-15, № 127<br><br>2.1. Онцгой дэглэмийн хугацаанд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааны хэвийн нөхцөл байдлыг бүрэн хангаж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараахь албан тушаалтанд даалгасугай: 2.1. “Эрдэнэт үйлдвэр” ХХК (хуучин нэрээр), “Монголросцветмет” ХХК (хуучин нэрээр)-ийн 2016-2019 оны үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг эрчимжүүлж, хууль зөрчсөн, ашиг сонирхлын зөрчилтэй, компанийн эрх ашигт нийцээгүй гэрээ хэлцэлтэй холбоотойгоор хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа асуудлыг яаралтай шийдвэрлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан), “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” ТӨҮГ-ын Захирал Б.Мөнхбат нарт; | дутагдлыг арилгах талаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br><br>Мөн “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК, “Кью Эс Си” ХХК, “Цемент шохой” ХК, “Монголиан коппер корпорэйшн” ХХК, “Цэц мөнх” ХХК, “Рэс” ХХК, "Гурван уул" ХХК, "Тайтлан Ресорсиз Монголиа" ХХК зэрэг хуулийн этгээдтэй холбоотой зарим асуудлыг шалгуулах нь зүйтэй гэж үзэж хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн. | | |
| | 81 | **“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2020-04-15, № 127<br><br>2.2. Лондонгийн олон улсын арбитрын шүүхийн шийдвэрээр “Эрдэнэт үйлдвэр” ХХК (хуучин нэрээр)-иас Стандарт банкинд төлсөн төлбөрийг буруутай этгээдээр буцаан шуурхай төлүүлэх талаар холбогдох хууль хяналтын байгууллагуудтай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан) “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Стандарт банктай холбоотой хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэх талаар Засгийн газраас чиглэл, удирдамж өгч ажилласны дүнд 2019 оны 04 дүгээр сарын эхээр 40.0 сая ам.долларыг Стандарт банкинд төлж, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын гадаад дахь өр төлбөрийн асуудал хаагдсан бол дотоодод энэ асуудал хууль, хяналтын байгууллагуудаар шалгагдаж, шүүхийн шатанд хянагдаж байна.<br><br>Онцгой дэглэм тогтоосноор үйлдвэрийн газрын үйл ажиллагаа жигдэрсэн бөгөөд шалгалтын актаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хууль зөрчсөн, ашиг сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхэд тодорхойгүй хугацаа шаардагдахаар байгаа болно. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 82 | **“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-04-15, № 127<br>2.3. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан төслийг үе шаттайгаар шуурхай хэрэгжүүлэхийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэнд, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулах, 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хангах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахал болон дэлхийн зах зээл дээрх металлын үнийн уналтаас үүсээд байгаа хүндрэлийг даван туулах хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж ажиллахыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” ТӨҮГ-ын Захирал Б.Мөнхбат нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээ аван ажилласан.<br>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах, 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хангах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар бүхий л боломжоо дайчлан ажиллаж байна. Мөн коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахал болон дэлхийн зах зээл дээрх металлын үнийн уналтаас үүсээд байгаа хүндрэлийг даван туулах хөтөлбөр, төлөвлөгөө гарган, сар бүр тайлагнан ажиллаж байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| | 83 | **“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-04-15, № 127<br>2.4. үндсэн ба эргэлтийн хөрөнгө, түүний дотор түүхий эд, материалын нийлүүлэлт, зарцуулалт, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хадгалалт, хуваарилалт, тээвэрлэлт, борлуулалтад тогтоосон тусгай хяналтыг үргэлжлүүлж ажиллахыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” ТӨҮГ-ын Захирал Б.Мөнхбат нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Үндсэн ба эргэлтийн хөрөнгө, түүний дотор түүхий эд, материалын нийлүүлэлт, зарцуулалт, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хадгалалт, хуваарилалт, тээвэрлэлт, борлуулалтад тогтоосон тусгай хяналтыг үргэлжлүүлэн, шинэчлэгдсэн дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| | 84 | **“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын талаар авах зарим арга хэмжээний тухай** | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Үйлдвэрийн газрууд нь хөдөлмөрийн болон үйлдвэрлэл, технологийн сахилгыг чанд сахин биелүүлэхэд чиглэсэн тухайлсан | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2020-04-15, № 127<br>2.5. шаардлагатай тохиолдолд үйлдвэрийн газарт хөдөлмөрийн болон үйлдвэрлэл, технологийн сахилгыг чанд сахин биелүүлэхэд чиглэсэн тухайлсан дүрэм, үйлдвэрлэлийн аюул осолгүй ажиллагааны болон олон нийтийн хэв журам сахиулах тусгай журам тогтоож, тэдгээрийг зөрчигчдөд зохих хариуцлага хүлээлгэж ажиллахыг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, "Монголросцветмет" ТӨҮГ-ын Захирал Б.Мөнхбат нарт; | дүрэм, үйлдвэрлэлийн аюул, осолгүй ажиллагааны болон олон нийтийн хэв журам сахиулах тусгай журмуудын хүрээнд ажиллаж байна. | | |
| | 85 | **"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Монголросцветмет" ТӨҮГ-ын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-04-15, № 127<br>2.8. улс, орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын төлөх татвар, хураамж, ногдол ашгийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан), "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, "Монголросцветмет" ТӨҮГ-ын Захирал Б.Мөнхбат нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Улс, орон нутгийн төсөвт эдгээр үйлдвэрийн газрын төлөх татвар, хураамж, ногдол ашгийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллав. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь 2019 онд борлуулалты орлогыг 119.5 тэрбум төгрөгөөр өсгөж, цэвэр ашгийг 516.8 тэрбум төгрөгт хүргэн улс, орн нутгийн төсөвт 961.8 тэрбум төгрөгийн татварыг, "Монголросцветмет" ТӨҮГ нь борлуулалтын орлогыг 56.5 тэрбум төгрөгөөр өсгөж, цэвэр ашгийг 34.6 тэрбум төгрөгт хүргэн, улс, орон нутгийн төсөвт 33.4 тэрбум төгрөгийн татварыг тус тус төвлөрүүлсэн. Харин 2020 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь борлуулалтын орлогыг 98.7 тэрбум төгрөгөөр өсгөж, цэвэр ашгийг 318.7 тэрбум төгрөгт хүргэснээр улс, орон нутгийн төсөвт 642.4 тэрбум төгрөгийн татварыг, "Монголросцветмет" ТӨҮГ нь борлуулалтын орлогыг 28.7 тэрбум төгрөгөөр өсгөж, цэвэр ашгийг 24.4 тэрбум төгрөгт хүргэн, улс, орон нутгийн төсөвт 30.8 тэрбум төгрөгийн татварыг тус тус төвлөрүүлээд байна.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 135 дугаар тогтоолоор 2020 онд улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчийн ногдол ашгийн хувь, хэмжээг 2019 оны цэвэр ашгаас тооцон тогтоож, шийдвэрлэсэн болно. 2020 онд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ 155.0 тэрбум төгрөгийн, "Монголросцветмет" ТӨҮГ 5.1 тэрбум төгрөгийн, нийт 160.1 тэрбум төгрөгийн төрийн өмчийн ногдол ашгийг улсын төсөв, "Ирээдүйн өв сан"-д төвлөрүүлэх төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн дүнтэй байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 86 | **“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-04-15, № 127<br>2.9. онцгой дэглэмийн үед үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрийн газрын эрх, ашиг сонирхолд нийцээгүй гэрээг талуудын хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүйгээр өөрчлөх эсхүл цуцлах арга хэмжээ авахыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” ТӨҮГ-ын Захирал Б.Мөнхбат нарт. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Онцгой дэглэмийн үед үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрийн газруудын эрх, ашиг сонирхолд нийцээгүй гэрээ байгуулаагүй болно. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| 54 | 87 | **Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв байгуулах тухай**<br>2020-04-15, № 136<br>2.3. хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай байр, тасалгаагаар хангах, хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Биеийн тамир, спортын газар (Ц.Шаравжамц), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Биеийн тамир спортын улсын хорооны харьяанд байгуулагдсан Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай хөрөнгийн асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 21 дүгээр хуралдаанаар хэлэлцээд 2020 оны 754 дүгээр тогтоолоор Боловсрол, шинжлэх ухааны яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 43 нэрийн 32.4 сая төгрөгийн эд хөрөнгийг Биеийн тамир, спортын улсын хороонд шилжүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 55 | 88 | **Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай**<br>2020-04-22, № 144<br>1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Коронавируст цар тахлын нөхцөл байдлын үед улс орны хэмжээнд авах арга хэмжээний хүрээнд төсвийн байгууллагуудад хэрэгжих хөрөнгө оруулалт болон нэг удаагийн шинжтэй арга хэмжээ, бүх төрлийн сургалт семинар, урлаг, спортын арга хэмжээ, гадаад, дотоод томилолт, урсгал болон их засвар, тавилга, тоног төхөөрөмж худалдан авах гэх мэт тэвчиж болох зардлын санхүүжилтийг Сангийн яамнаас хязгаарласан байгаа тул хэрэгжилт хангагдаагүй байна. Хэрэгжих хугацаа болоогүй. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| 56 | 89 | **Тогтоолын хавсралтад нэмэлт,** | **ТӨБЗГ – ЗУХ** | “Бүрэн хэрэгжсэн” – | Хэрэгжсэн тул |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **өөрчлөлт оруулах тухай**<br>2020-04-29, № 151<br>3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, цаашид жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгасугай. | 2020 онд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг эрх нь үүссэн төрийн захиргааны 5, төрийн үйлчилгээний 2 албан хаагчид, төрийн захиргааны 4 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг шинээр болон нэмэгдүүлэн тус тус олгосон. Байгууллагын 4 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарсан бөгөөд шаардлагатай хөрөнгийг 2020 оны төсөвт суулгасны үндсэн дээр тэдгээр албан хаагчдад нийт 92,104.1 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгосон байна.<br>Цаашид тус тогтоолд заасны дагуу хүний нөөцийн судалгаа, тооцоонд үндэслэн шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | 100% | хяналтаас хасах саналтай. |
| 57 | 90 | **Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай**<br>2020-05-06, № 163<br>3. Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Агентлаг байгуулах тухай” 438 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэг өөрчлөгдөж, зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлангийн системд Төрийн худалдан авах газарт шилжин ажиллаж байгаа албан хаагчдын мэдээллийг хасч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын мэдээллийг шинэчлэн оруулсан байна.<br>Төрийн албаны зөвлөл, Сангийн яамны хамтран хэрэгжүүлж байгаа албан хаагчийн цалин хөлсний хяналтын цахим систем https://payroll.gov.mn -ийг нэвтрүүлэн ТӨБЗГ-ын албан хаагчдын мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулж, мэдээлэлтэй уялдуулан 9 дүгээр сараас цалинг бодож олгов. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| 58 | 91 | **Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай**<br>2020-05-06, № 168<br>3.2.Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулах замаар энэ тогтоолын 1 дэх заалтад заасан төсвийн зохицуулалтыг тусган баталж мөрдүүлэхийг Сангийн сайд | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Сангийн яамнаас баталсан шинэчилсэн хуваарийн дагуу төсвийн зарцуулалтад зохицуулалт хийгдсэн. Түүний дагуу байгууллагын 2020 оны төсвийг зарцуулж, тогтоосон хуваарийн дагуу тайлагнав. Өр, авлага үүсээгүй. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Ч.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй.<br>3. Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу төрийн үйлчилгээг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй байхаар үйл ажиллагааг зохион байгуулж төсвийн сахилга хариуцлагыг өндөржүүлэн ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай. | | | |
| 59 | 92 | **Орон сууц хувьчлах тухай**<br>2020-05-20, № 180<br>2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан 9 (есөн) орон сууцыг эзэмшигчдэд нь үнэ төлбөргүй хувьчилсугай. 2. Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 9 (есөн) орон сууцыг эзэмшигчдэд нь үнэ төлбөргүй хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах хүрээнд холбогдох нягтлан шалгах, судалгаа хийх ажлыг гүйцэтгэж, эзэмшигчид нь Орон сууц эзэмших эрхийн бичиг олгохоор материал бүрдүүлэв.<br>Уг 9 (ес) орон сууцыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан хаагчдад хувьчлахаар шийдвэрлэсний дагуу эдгээр 9 айлын орон сууцыг эзэмшиж буй албан хаагчдад хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд “Орон сууц эзэмших эрхийн бичиг”-ийг олгосон. “Орон сууц эзэмших эрхийн бичиг”-ийг олгосонтой холбогдуулан Нийслэлийн орон сууц хувьчлах товчоонд “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ” олгуулах хүсэлтийг хүргүүлсэн болно. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 60 | 93 | **Орон сууц хувьчлах тухай**<br>2020-06-01, № 210<br>2. Орон сууцыг хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Оросын Холбооны Улсын өмчөөс Монгол Улсын өмчлөлд үнэ төлбөргүй шилжин ирсэн орон сууцны 8 байрны 505 айлын орон сууцыг эхний ээлжинд тухайн оршин суугчдад нь хувьчлахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас эдгээр орон сууцны 8 байрны 505 айлд “Орон сууц эзэмших эрхийг бичиг” олгох ажлыг зохион байгуулж ажиллалаа. Энэ ажлын хүрээнд Улаанбаатар хотын 6 байрны 395 айлын орон сууц, Дархан-Уул аймгийн 110 айлын орон сууцыг эзэмшиж буй иргэдэд “Орон сууц эзэмших эрхийн бичиг”-ийг олгоод байна. Дээрх 8 байрны 505 айлын оршин суугчдад “Орон сууц эзэмших эрхийн бичиг”-ийг олгосонтой холбогдуулан Нийслэлийн орон сууц хувьчлах товчоо, Дархан-Уул аймгийн орон сууц хувьчлах товчоонд “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ” олгуулах | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хүсэлтийг хүргүүлсэн болно. | | |
| 61 | 94 | **Агентлаг байгуулах тухай**<br>2020-06-23, № 230<br>9. Чиг үүрэг нь шилжиж байгаатай холбогдуулан Ашигт малтмал, газрын тосны газраас Үндэсний геологийн албанд чиг үүргийн хувьд шилжих орон тоог холбогдох төсөв, хөдлөх хөрөнгийн хамт шилжүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн), Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ - ТӨБАХ**<br>ТӨБЗГ-ын 2020 оны 511, 548 дугаар тогтоолоор Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 378 нэрийн 38.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг Үндэсний геологийн албанд балансаас балансад шилжүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 62 | 95 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай**<br>2020-08-19, № 60<br>2.“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Нийслэлийн Сүхбаатар дүүрэгт байрлах 113,816,400.00 (нэг зуун арван гурван сая найман зуун арван зургаан мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ, 20,268,673.96 (хорин сая хоёр зуун жаран найман мянга зургаан зуун далан гурван төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан барилгыг Цагдаагийн ерөнхий газрын харьяа Экологийн цагдаагийн албанд балансаас балансад шилжүүлсүгэй.<br>2. Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 113.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий барилгыг Экологийн цагдаагийн газарт балансаас балансад шилжүүлж, 2020 оны санхүүгийн тайлан балансад тусгуулах арга хэмжээ авсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 63 | 96 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад** | **ТӨБЗГ – ТӨБАХ** | “Бүрэн | Хэрэгжсэн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **шилжүүлэх тухай**<br>2020-09-02, № 88<br>2.Тагнуулын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэр Ерөнхий сайд Амарын гудамжинд байрлах Төрийн тусгай хамгаалалтын газрын төв байрлаж байгаа 5 давхар барилгыг Төрийн тусгай хамгаалалтын газарт балансаас балансад шилжүүлсүгэй. 2. Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, санхүүгийн тайланд тусгасан. | хэрэгжсэн" – 100% | тул хяналтаас хасах саналтай. |
| 64 | 97 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай**<br>2020-09-02, № 89<br>2.Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 409 дүгээр хаалттай хорих ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Нийслэлийн Баянзүрх дүүрэгт байрлах 654.67 сая төгрөгийн балансын үнэ, 22.97 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Ялтны байрыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвд шилжүүлж, 2020 оны тайлан балансад тусгуулах арга хэмжээ авсан. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 65 | 98 | **Төрийн өмчит үйлдвэрийн газрын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-09-02, № 93<br>5.Улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулсантай холбогдуулан хууль тогтоомжийн дагуу комисс томилж, эд хөрөнгөд тооллого хийж, үндсэн болон бусад эд хөрөнгө, албан хэрэг, архивыг шинээр байгуулагдсан хуулийн этгээдэд шилжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т үүрэг | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв" УТҮГ, "Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци" ТӨҮГ-ыг нийлүүлэх замаар "Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төв" УТҮГ байгуулсантай холбогдуулан Ажлын хэсэг байгуулагдан эд хөрөнгөд тооллого хийж, үндсэн болон бусад эд хөрөнгө, албан хэрэг, архивыг шинээр байгуулагдсан байгууллагад шилжүүлэн өгсөн. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | болгосугай. | | | |
| 66 | 99 | **Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, зөвшөөрөл олгох, төмөр замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээний тухай**<br>2020-09-23, № 117<br>3.“Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн хувьцааг хаалттай хүрээнд нэрлэсэн үнээр худалдах замаар нийт хувьцааны 66 хувийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д тус тус эзэмшүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т, цаашид “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу үе шаттай шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Артур), “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Баярсайхан)-д тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр болсон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “Эрдэнэс-Тавантолгой” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүдийг үндэслэн “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийг үүсгэн байгуулах тогтоолыг баталж, компанийг байгуулан үйл ажиллагааг эхлүүлээд байна. “Зүүнбаян төмөр зам” ХХК нь 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн бөгөөд “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн гүйцэтгэх захирлаар Д.Банзрагчийг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс томилсон. Одоогийн байдлаар “Зүүнбаян төмөр зам” ХХК нь 18 үндсэн ажилтантайгаар үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| | 100 | **Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, зөвшөөрөл олгох, төмөр замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээний тухай**<br>2020-09-23, № 117<br>4.“Монголын төмөр зам” ТӨХК-иас Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд зарцуулсан хөрөнгөд хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах, хөндлөнгийн аудит хийлгэхэд шаардагдах зардлыг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2020 оны зорилтот түвшний үзүүлэлтийг тодотгох замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Одоогоор аудит хийгдээгүй байгаа болно. Үндэсний аудитын газарт 2 удаагийн албан бичгээр аудит хийлгэх хүсэлтээ илгээсэн боловч 2020 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй тул 2020 онд хийх боломжгүй тухай хариуг ирүүлсэн болно. | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хөгжлийн сайд Л.Халтар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Артур)-д тус тус зөвшөөрсүгэй. | | | |
| | 101 | **Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах, зөвшөөрөл олгох, төмөр замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээний тухай**<br>2020-09-23, № 117<br>7.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан “Монголын төмөр зам” ТӨХК болон “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хооронд байгуулсан “Үнэт цаас худалдах, худалдан авах гэрээ”, “Үнэт цаас худалдах, худалдан авах гэрээ”-г хэрэгжүүлэхтэй холбоотой хамтын ажиллагааны гэрээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Артур), “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Баярсайхан)-д даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Монголын төмөр зам” ТӨХК болон “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хооронд байгуулсан “Үнэт цаас худалдах, худалдан авах гэрээ”, “Үнэт цаас худалдах, худалдан авах гэрээ”-г хэрэгжүүлэхтэй холбоотой хамтын ажиллагааны гэрээ”-нд нэмэлт, өөрчлөлт ороогүй байгаа болно. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| 67 | 102 | **“Дархан арьс ширний цогцолбор” төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-09-23, № 118<br>1.Дархан-Уул аймгийн Хонгор суманд хэрэгжиж байгаа “Дархан арьс ширний цогцолбор” төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зайлшгүй шаардлагыг харгалзан хөрөнгийн зарим эх үүсвэрийг улсын төсвөөс гаргах, шаардлагатай бол хөрөнгө оруулалтаар тооцох боломжтой эсэхийг судалж, саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Төрийн өмчийн бодлого, | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>ХХААХҮ-ийн сайдын тушаалаар ажлын хэсэг томилон ажиллуулж Дархан-Уул аймгийн Хонгор суманд хэрэгжиж байгаа “Дархан арьс ширний цогцолбор” төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зайлшгүй шаардлагыг харгалзан хөрөнгийн зарим эх үүсвэрийг улсын төсвөөс гаргах, шаардлагатай бол хөрөнгө оруулалтаар тооцох боломжтой эсэхийг судалж, дүгнэлт, санал боловсруулан Засгийн газарт хүргүүлсэн. Дүгнэлт, саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын 2020 оны 185 дугаар тогтоолоор шийдвэрлэж, “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | | | |
| 68 | 103 | **Орон сууц хувьчлах тухай**<br><br>2020-10-14, № 145<br><br>2.Дархан-Уул аймгийн Уул уурхай, эрчим хүчний политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан 8 айлын орон сууцыг одоо эзэмшиж байгаа албан хаагчдад нь үнэ төлбөргүй хувьчилсугай. 2. Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ - ТӨУЗХ**<br>Дархан-Уул аймгийн Уул уурхай, эрчим хүчний политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 8 (найм) орон сууцыг хувьчлахаар шийдвэрлэсний дагуу эдгээр 8 айлын орон сууцыг эзэмшиж буй албан хаагчид нь “Орон сууц эзэмших эрхийн бичиг”-ийг хууль тогтоомжийн дагуу олгосон.<br>Дээрх 8 албан хаагчид “Орон сууц эзэмших эрхийн бичиг”-ийг олгосонтой холбогдуулан Дархан-Уул аймгийн орон сууц хувьчлах товчоонд “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ” олгуулахаар хүсэлтийг хүргүүлсэн болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | ТӨБЗГ нь хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 69 | 104 | **Орон сууц хувьчлах тухай**<br><br>2020-10-14, № 146<br><br>1.Оросын Холбооны Улсын өмчлөлөөс Монгол Улсын өмчлөлд шилжин ирсэн нийслэлийн Баянгол дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 17 дугаар байрны 7 айлын орон сууц, Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 11 дүгээр байрны 8 айлын орон сууц, 12 дугаар байрны 7 айлын орон сууц, 13 дугаар байрны 6 айлын орон сууц, Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 1 дүгээр байрны 2 айлын орон сууц, 7 дугаар байрны 4 айлын орон сууц, Дархан-Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах 3 дугаар байрны 5 айлын орон сууц, 4 дүгээр байрны 5 айлын орон сууц, нийт 44 айлын орон сууцыг хавсралтад заасан оршин суугчдад нь үнэ төлбөргүй хувьчилсугай.<br><br>2.Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br><br>Оросын Холбооны Улсын өмчөөс Монгол Улсын өмчлөлд шилжин ирсэн орон сууцны 8 байрны 549 айлаас хувьчлагдаагүй үлдсэн 44 айлын орон сууцыг хувьчлахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас орон сууцны 8 байрны 44 айлд “Орон сууц эзэмших эрхийг бичиг” олгох ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан.<br><br>Энэ ажлын хүрээнд Улаанбаатар хотын 6 байрны 34 айлын орон сууц, Дархан-Уул аймгийн 10 айлын орон сууцанд оршин суугч иргэдэд нь “Орон сууц эзэмших эрхийн бичиг”-ийг олгоод байна. Дээрх 8 байрны 44 айлын оршин суугчид “Орон сууц эзэмших эрхийн бичиг”-ийг олгосонтой холбогдуулан Нийслэл болон Дархан-Уул аймгийн Орон сууц хувьчлах товчоонд “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ” олгуулахаар хүсэлтийг хүргүүлсэн болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | ТӨБЗГ нь хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | даалгасугай. | | | |
| 70 | 105 | **Орон сууц хувьчлах тухай**<br>2020-11-11, № 173<br>2.Хууль зүй, дотоод хэргийн яам, Онцгой байдлын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан 6 айлын орон сууцыг одоо эзэмшиж байгаа ажилтан, албан хаагчдад нь үнэ төлбөргүй хувьчилсугай. 2. Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Хууль зүй, дотоод хэргийн яам, Онцгой байдлын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 6 (зургаа) орон сууцыг хувьчлахаар шийдвэрлэсний дагуу эдгээр 6 айлын орон сууцыг эзэмшиж буй албан хаагчдад нь эзэмшүүлэх тухай “Орон сууц эзэмших эрхийн бичиг”-ийг хууль тогтоомжийн дагуу олгосон.<br>Дээрх 6 албан хаагчдад “Орон сууц эзэмших эрхийн бичиг”-ийг олгосонтой холбогдуулан Дархан-Уул аймгийн Орон сууц хувьчлах товчоонд “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ” олгуулах хүсэлтийг хүргүүлсэн болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | ТӨБЗГ нь хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 71 | 106 | **Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-11-18, № 183<br>18.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлбөрийг түргэн шуурхай барагдуулж ажиллахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Монгол Улсад коронавируст халдвар /КОВИД-19/-ын тохиолдол бүртгэгдсэн нөхцөл байдлын улмаас Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар байгуулагдсан “Шуурхай штаб” холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ аван ажилласан. Энэ хүрээнд агентлагийн дотоод үйл ажиллагаа болон өөрийн хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд шууд удирдлагаар хангах үүрэг бүхий төрийн өмчит үйлдвэрийн газар (Төрийн өмчит үйлдвэрийн газар-23), Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани (ТӨХХК-2), Төрийн өмчит хувьцаат компани (ТӨХК-22), Төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани (ТӨОХК-3), нийт 50 хуулийн этгээдэд Засгийн газрын энэхүү шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах чиглэл хүргүүлэв.<br>ТӨБЗГ-ын “Шуурхай штаб” удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эхний ээлжинд байгууллагын ажлын дотоод зохион байгуулалт, ажлын цагийн горимд зохих өөрчлөлт оруулж, газрын хэмжээнд ажиллагсдын өрөө, тасалгааны ариутгал, амны хаалтны нөөцийг бүрдүүлж, бий болох нөхцөл байдалд нийцүүлэн үйл ажиллагаагаа төлөвлөн шуурхай зохион байгуулж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| | 107 | **Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн** | **ТӨБЗГ – ЗУХ, ТӨУЗХ**<br>Цар тахлын үед худалдан авч байгаа бараа, бүтээгдэхүүнийг | “Бүрэн хэрэгжсэн” – | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-11-18, № 183<br>19.Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, дотоодын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10, 10[1] дүгээр зүйлд заасныг баримтлан дотоодын барааг худалдан авах зохион байгуулалтын арга хэмжээг авахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай. | дотоодын үйлдвэрлэгчээс худалдан авах чиглэлийг барьж байгаа болно. Худалдан авах бараа, бүтээгдэхүүн чанар, шаардлагыг хангасан байх шалгуурыг баримталж байна. | 100% | |
| | 108 | **Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-11-18, № 183<br>20.Аж ахуйн нэгжийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангах зорилгоор бэлэн байдал зарласан хугацаанд хүлээн авах бүх төрлийн сонгон шалгаруулалтын хугацааг 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдөр хүртэл сунгахыг төсвийн бүх шатны захирагч нарт үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ЗУХ, ТӨУЗХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 3 төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг энэ тогтоолоор сунгасан хугацааг баримталж, зохион байгуулсан болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| 72 | 109 | **Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай**<br>2020-11-18, № 185<br>3. “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг Засгийн газраар батлуулж, үйл ажиллагааг нь зохих журмын дагуу эхлүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Төрийн | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Энэ тогтоолоор “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн байгуулж, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг байхаар тогтоосон.<br>Шинээр байгуулагдсан “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 234 дүгээр тогтоолоор баталж, “Дарханы арьс ширний цогцолбор” төслийг хэрэгжүүлэхдээ төрийн өмчит хуулийн этгээд болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр хөрөнгө, | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | санхүү хариуцлага, хугацаа, эрх, үүргийг нарийвчлан тодорхойлсон гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад даалгасан байна. Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд ТӨБЗГ-ыг төлөөлж төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнийг томилуулах саналыг Х Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн болно. | | |
| 73 | 110 | **Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай**<br><br>2020-11-23, № 187<br><br>2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын батлагдсан төсвийн хэмнэлтийг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль үйлчлэх хугацаанд тухайн салбарын хэмжээнд цар тахалтай тэмцэх арга хэмжээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах эрхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгосугай. Төсвийн зохицуулалтын батлагдсан хуваарийн дагуу төрийн үйлчилгээг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй байхаар зохион байгуулж, төсвийн сахилга, хариуцлагыг өндөржүүлэн ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ЗУХ, ТӨУЗХ**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Монголын Улсын Засгийн газраас цар тахалтай тэмцэх, сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр гаргасан шийдвэр, Улсын онцгой комиссын даргын тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний удирдамж”-ийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлдэг 50 хуулийн этгээдийн захиралд Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах талаар холбогдох үүрэг, чиглэл өгч ажиллав.<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар улс орны стратегийн ач холбогдол бүхий цар хүрээ өргөнтэй үйл ажиллагаа явуулдаг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголроссцветмет” ТӨҮГ, харилцаа, холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК, “Монголын цахилгаан холбоо” ХК, “Монгол шуудан” ХК, шатахуун, шингэн түлш импортлох, нөөцлөх чиг үүрэг бүхий “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ, авто тээвэр зохицуулалтын чиглэлээр төрийн зарим чиг үүрэг хэрэгжүүлдэг “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ гэсэн нийт 7 байгууллагад дээрх нийтлэг чиглэл, зөвлөмжөөс гадна тусгайлсан чиглэл өгч, хууль, тогтоомжид заасны дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах, цаашид нөхцөл байдалд үнэлэлт өгч, үйл ажиллагаагаа эрсдэлгүй, нарийвчилсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажиллахыг анхааруулан холбогдох мэдээ, тайланг өдөр бүр авч ажилласан байна. Доголдол, хүндрэл гараагүй байна.<br><br>ТӨБЗГ нь Сангийн яамнаас баталсан шинэчилсэн хуваарийн дагуу төсвийн зарцуулалтад зохицуулалт хийгдсэн. Түүний дагуу байгууллагын 2020 оны төсвийг зарцуулж, тогтоосон хуваарийн дагуу тайлагнав. Өр, авлага үүсээгүй. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| 74 | 111 | **Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай**<br><br>2020-11-29, № 194<br><br>7. Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт | **ТӨБЗГ – ЗУХ, Шуурхай штаб**<br><br>Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, урьдчилан сэргийлэх, халдвар, | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан хязгаарлалтыг авч, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, бүх шатны боловсролын байгууллага, иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай. | хамгааллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангах, албан хаагчдын ажлыг тусгай горимд шилжүүлэх, эрүүл мэнд, онцгой байдлын байгууллагын зөвлөмж, удирдамжийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ аван ажиллаж байна. Байгууллагад "Шуурхай штаб"-ыг байгуулан ажиллуулсан. Халдвар хамгааллын дэглэм, урьдчилан сэргийлэх хэрэгслийн нөөц бүрдүүлэх зэрэг арга хэмжээнд нийт 6.5 сая төгрөгийг байгууллагын батлагдсан төсвөөс зарцуулаад байна. | | |
| 75 | 112 | **Сайжруулсан шахмал түлшний талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2020-12-02, № 200<br>1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын улмаас Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан нийслэлийн гэр хорооллын иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сайжруулсан шахмал түлшний нэг тонн тутмын үнийг 50 хувиар хөнгөлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрөөс 2021 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Таван толгой түлш" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ж.Батбаясгалан)-д тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээг баталсан. Энэ тогтоолд заасан сайжруулсан шахмал түлшний нэг тонн тутмын үнийг 50 хувиар хөнгөлөх хэмжээг үе шаттайгаар нийт 75 хувиар хөнгөлөхөөр өөрчлөлт оруулснаар хэрэгжилтийг зохион байгуулж байна. Үүнтэй холбоотойгоор "Таван толгой түлш" ХХК-ийн сайжруулсан шахмал түлшийг 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 13-ны өдрийг хүртэл 50 хувийн хөнгөлөлттэй үнээр, 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс 75 хувийн хөнгөлөлттэй үнээр борлуулж эхэлсэн. 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сайжруулсан шахмал түлшний 679 борлуулалтын цэгээр дамжуулан нийслэлийн гэр хорооллын иргэдэд хөнгөлөлттэй үнээр түлшний дэмжлэг үзүүлсэн байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |
| | | **ЗГТогтоол: 59 шийдвэрийн 89 заалт** | **100%-62 заалт; 70%-15 заалт; 30%-1 заалт; 0%-1 заалт;<br>ХБ/ҮБ–10 заалт; Хэрэгжилтийн хувь – 92.2%.** | | **Хасах санал: 54** |
| **Долоо. Ерөнхий сайдын захирамж** | | | | | |
| 76 | 113 | **Төлөвлөгөө батлах тухай**<br>2020-07-01, № 99 | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр байгууллагын нийт | "Хэрэгжилтийг тооцох хугацаа | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)”-г хавсралт ёсоор батлсугай.<br>2. Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг салбарын болон орон нутагт хэрэгжүүлэх жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн холбогдох байгууллагын төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | албан хаагчдад холбогдох хууль тогтоомж, төлөвлөгөөг танилцуулж, ойлголт мэдээлэл өгсөн. Цаашид төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. | болоогүй” – ХБ. | |
| 77 | 114 | **Ажлын хэсэг байгуулах тухай**<br>2020-09-07, № 43<br>4. Төрийн өмчит хуулийн этгээд (Улсын төсөвт үйлдвэрийн газар, Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Төрийн өмчит компани, Төрийн өмчийн оролцоотой компани)-ийн эрх зүйн байдал, зааг ялгаа, чиг үүргийг судалж, тэдгээрийн үйл ажиллагаанд цогц байдлаар дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай: Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг 2020 оны 10 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Цэнгэл)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ**<br>Ажлын хэсгийн ажлын хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны А/60, 2020 оны А/60 дугаар тушаалаар хоёр дэд ажлын хэсэг байгуулан Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж, 5 удаа хуралдсан. Дэд ажлын хэсгүүд дараах чиглэлээр ажиллаж, холбогдох дүгнэлтийг бэлтгээд байна:<br>– Төрийн өмчит хуулийн этгээдийн чиг үүрэг, хүний нөөц, цалин урамшууллын систем, ажиллагсдын тоо, ажлын бүтээмж, төсөв, төлөвлөгөө бодитой байгаа эсэхийг судалж, Улсын төсөвт үйлдвэрийн газар, Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, Төрийн өмчит компани, Төрийн өмчийн оролцоотой компани тус бүрээр дүгнэлт гаргах;<br>– Хуулийн этгээдүүд нь бодлогын баримт бичгийн хүрээнд ажлаа төлөвлөж, холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа эсэх, хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт, тухайн хуулийн этгээдэд хийж байгаа улсын төсвийн хөрөнгө оруулалтуудын үр өгөөж бодитой байгаа эсэхийг дүгнэх;<br>– Хуулийн этгээдүүд нь бодлогын баримт бичгийн хүрээнд ажлаа төлөвлөж, холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа эсэх, хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт, тухайн хуулийн этгээдэд хийж байгаа улсын төсвийн хөрөнгө оруулалтуудын үр өгөөж бодитой байгаа эсэхийг дүгнэх;<br>– Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бүтэц, | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | зохион байгуулалт оновчтой байгаа эсэх, гүйцэтгэх удирдлага болон удирдах албан тушаалнуудын тоо бодитой эсэхийг судалж дүгнэлт гаргах;<br>– Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ангилал, эрх зүйн байдал, чиг үүрэг, хүний нөөц, цалин урамшуулалын систем, ажиллагсдын тоо, ажлын бүтээмж, төсөв, төлөвлөгөө бодитой байгаа эсэхийг судалж дүгнэлт гаргах.<br><br>Мөн төрийн өмчит компаниудаас болон нийслэл, 21 аймгийн өмчийн асуудал хариуцсан байгууллагаас судалгааг авч нэгтгэн, дүн шинжилгээ хийсэн бөгөөд Засгийн газарт танилцуулахаар бэлтгэж байна. Судалгаа, дүгнэлт, саналд орон нутгийн өмчийн компаниудыг оролцуулж байгаа тул мэдээлэл цуглуулах, нягтлах, дүгнэх ажилд цаг хугацаа зарцуулагдаж байгаа болно. | | |
| | | **ЕС-ын захирамж: 2 шийдвэрийн 2 заалт** | **70% - 1 заалт; ХБ/ҮБ- 1 заалт; Хэрэгжилтийн хувь – 70.0%.** | | **Хасах санал: 0** |
| **Найм. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 78 | 115 | **Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай**<br><br>2017-09-13, № 39<br><br>XXII.2.1. 2017 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль тогтоомжийн дагуу дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчийг давуу эрхээр шалгаруулж байгааг сайшаан, цаашид дотоодын аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов. | **ТӨБЗГ – ЗУХ**<br><br>2020 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь өөрийн байгууллагын хэрэгцээнд шаардлагатай барааны 3 худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан бөгөөд 2 нь нээлттэй сонгон шалгаруулалтын журмаар, уламжлалт аргаар, 1 нь шууд худалдан авалт байна. 2020 оны төсвийн жилд зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны холбогдох төлөвлөгөө, зар мэдээлэл, тайланг ил тод, нээлттэй мэдээлэх арга хэмжээ авсан.<br><br>Цар тахлын үед худалдан авч байгаа бараа, бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчээс худалдан авах чиглэлийг барьж байгаа болно. Худалдан авах бараа, бүтээгдэхүүн чанар, шаардлагыг хангасан байх шалгуурыг баримталж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| | 116 | **Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай**<br><br>2017-09-13, № 39<br><br>XXII.2.2. Төсвийн болон төслийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа худалдан авах ажиллагааны явцын мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын | **ТӨБЗГ – ЗУХ**<br><br>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Агентлаг байгуулах тухай” 438 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэг өөрчлөгдөж, Ерөнхий сайдын 2020 оны 06 дугаар захирамжаар байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэн батлагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны чиг үүрэг шинээр байгуулагдсан агентлагт шилжсэн тул Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | Хяналтаас хасуулах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | газарт хүргүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | хамаарахгүй байна. | | |
| 79 | 117 | **Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай тайлан, үнэлгээний дүнгийн тухай**<br>2019-03-21, № 11<br>23.12.2. Худалдан авах ажиллагааны цахим системийн үйл ажиллагааг сайжруулах, статистик тоон мэдээллийн давхардалгүй, үнэн зөв байдлыг хангах, Ерөнхий гэрээ байгуулах ажлыг эхлүүлэхтэй холбоотойгоор цахим дэлгүүрийн хэвийн ажиллагааг хангаж, холбогдох гарын авлагыг боловсруулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгав. | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Агентлаг байгуулах тухай” 438 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэг өөрчлөгдөж, Ерөнхий сайдын 2020 оны 06 дугаар захирамжаар байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэн батлагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны чиг үүрэг шинээр байгуулагдсан агентлагт шилжсэн тул Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хамаарахгүй байна. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | Хяналтаас хасах саналтай. |
| 80 | 118 | **Албан татварын төлөх хугацааг сунгах тухай**<br>2019-04-10, №16<br>YIII.2. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрсний хэрэглээг хориглох арга хэмжээ авсантай холбогдуулан “Цогцолборыг шилжүүлэх, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх тухай” Засгийн газрын 2017 оны 48 дугаар тогтоолоор Батлан хамгаалах яамны мэдэлд шилжүүлсэн барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор (UBM)-ыг сайжруулсан түлшний үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүнийг нөөцлөх барилга байгууламж барих болон бусад арилжааны зорилгоор ашиглахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгав. | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ**<br>Үүсээд байгаа нөхцөл байдлын талаар танилцуулж, чиглэл авахаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2020 оны А-1/617 дугаартай албан бичгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн бөгөөд 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн ХЭГ/1555 дугаартай албан бичгээр хариу ирүүлсэн.<br>Зээлийн барьцаанд байгаа хөрөнгийн өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэлгүйгээр балансаас балансад шилжүүлэх шийдвэр гаргах боломжгүй байгаа. Харин хөрөнгийг Батлан хамгаалах яаманд хүлээлгэн өгч хадгалуулж байгаа болно. | “Хэрэгжээгүй” – 0 % | |
| | 119 | **Албан татварын төлөх хугацааг сунгах тухай** | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ**<br>Өр төлбөрийн асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас хэрэгжих | “Хэрэгжээгүй” – 0 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2019-04-10, №16<br>ҮIII.3. Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор (UBM)-ын ашиглалтаас олох орлогыг Хөгжлийн банкны зээл, зээлийн хүүг эргэн төлөхөд зарцуулахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгав. | боломжгүй байгаа. Өр зээлийн барьцаанд байгаа уг төхөөрөмжийг балансаас балансад шилжүүлэн төрийн өмчид бүртгэх боломжгүй.<br>Хөгжлийн банкны зээлийг хаах хүндрэлтэй асуудлаар Сангийн яаманд хүсэлт тавих, шаардлагатай бол Засгийн газрын хуралдаанд шийдвэрлүүлэх талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас чиглэл өгсөн болно. Энэ чиглэлийг Батлан хамгаалах яаманд уламжилсан. Хөгжлийн банкнаас уг байгууламжийг зээлийн барьцаалбарт байгаа талаар мэдэгдсэн тул шийдвэрийг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч, хойшлогдож байгаа болно. | | |
| 81 | 120 | **“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын 2016-2019 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай**<br>2019-05-22, № 23<br>XIII.14-2. Шалгалтын ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” ТӨҮГ-ын захирал Б.Мөнхбат нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т тус тус даалгав. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Шалгалтын ажлын хэсгийн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар хийсэн ажлын тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажилд хяналт тавин ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэрэгжилт тогтмолжиж байгаа, хяналт тавих ажил чиг үүргийн дагуу үргэлжилнэ.<br>Тэмдэглэлийг хяналтаас хасах саналтай. |
| 82 | 121 | **“Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн IY конгресс”-ыг Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулах ажлын хүрээнд авах арга хэмжээний тухай**<br>2019-05-29, № 24<br>XX.11. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд даалгав:<br>1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 1.1.конгрессыг угтсан ажлын төлөвлөгөө гарган, шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх; 1.2.Хөдөлмөрийн тухай | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэн ажиллах хүсэлт гаргаагүй.<br>Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэнийг авч ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд холбогдох төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэхэд шаардагдах зардлыг 2019, 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөлд тусган санал өгсөн боловч эрх бүхий байгууллага батлаагүй. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | Шаардлагатай төсөв батлагдахгүй байгаа тул цаашид хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хуулийн 111 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 128 дугаар зарлиг, Засгийн газрын 2019 оны 111 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг байнгын ажлын байраар хангах санаачилга гаргах; 1.3.хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэлийг дэмжих, бараа бүтээгдэхүүний нь худалдан авах; 1.4.барилга, байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох. | | | |
| 83 | 122 | **Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай**<br>2019-10-02, № 42<br>X. Авто замын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүргийг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т хариуцуулан ажиллуулах, тус үйлдвэрийн газрын дүрмийг шинэчлэн батлах, шаардлагатай бол зохион байгуулалтын бүтэц, орон тоог өөрчлөн тогтоох арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тус тус даалгав. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын шинэчилсэн дүрэм, өөрчлөлт оруулсан бүтэц, орон тооны төслийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 1/848 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд санал авахаар хүргүүлсэн. Зам, тээврийн хөгжлийн яамнаас төслийг хянаж, ирүүлсэн саналыг тусгаж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 126 дугаар тогтоолоор “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсан болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| | 123 | **Ерөнхий сайдын Орхон, Булган, Хөвсгөл аймагт ажилласан мөрөөр авах арга хэмжээний тухай**<br>2019-10-02, № 42<br>XYI.7. Орон нутгийн удирдлага, иргэдийн зүгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан санал, хүсэлтийг шийдвэрлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх талаар холбогдох Засгийн газрын гишүүд, Орхон аймгийн Засаг дарга, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дарга нарт | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Орон нутгийн удирдлага, иргэдийн зүгээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан санал, хүсэлтийг шийдвэрлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хамаарах “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 375 айлын орон сууцыг ажилтнуудад хувьчлах асуудлыг үе шаттайгаар зохион байгуулах, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэх санхүүжилтийг судлах, жил бүрийн төлөвлөгөөнд тусган үе шаттай шийдвэрлэх ажлыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д тусган Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн 262 дугаар тогтоолоор баталсан. Уг үндсэн чиглэлд эдгээр ажлууд тодорхой хугацаа, хуваарийн дагуу шийдвэрлэгдэхээр | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Хэрэгжих үндэслэл бүрдсэн тул цаашид хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | даалгав. (Төлөвлөгөөнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай холбоотой 2 асуудал тусгагдсан) | төлөвлөгдсөн байна. | | |
| 84 | 124 | **Хөрөнгө оруулалтын цэнхэр, ягаан тасалбараар хийгдсэн өмч хувьчлалын талаар хийсэн ажлын хэсгийн санал, дүгнэлтийн тухай**<br>2019-12-11, № 54<br>XXIX.1.2. Төрөөс төрийн өмчийн талаар болон өмч хувьчлал, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг тодорхой болгох, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-ын болон олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэн боловсруулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Төрөөс төрийн өмчийн талаар болон өмч хувьчлал, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг тодорхой болгох, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-ын болон олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн А/174 дүгээр тушаалаар тус яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулан байгуулсан. Уг ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэлтсийн дарга нар, холбогдох албан хаагчдын төлөөлөл томилогдон ажиллаж байна.<br>Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь хуулийн төсөл боловсруулахад МУИС-ийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн багш, УИХ-ын зөвлөхүүдийг татан оролцуулах арга хэмжээ авч, ТӨБЗГ-т дэд ажлын хэсгийг байгуулан хамтран ажиллаж байна.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн үзэл баримтлалыг боловсруулан ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Түүнчлэн, төрийн болон орон нутгийн өмчийн талаар мэдээлэл, судалгаа танилцуулгыг бэлтгэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт хүргүүлэв.<br>Уг хуулийн төслийн шинэчилсэн найруулга нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө болон Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан. | “Хэрэгжих шатанд” – 70 % | |
| | 125 | **Хөрөнгө оруулалтын цэнхэр, ягаан тасалбараар хийгдсэн өмч хувьчлалын талаар хийсэн ажлын хэсгийн санал, дүгнэлтийн тухай**<br>2019-12-11, № 54<br>XXIX.1.3. Өмч хувьчлалын 1991-1996 оны нэгдсэн мэдээлэл, судалгааг бүрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Архивын ерөнхий газар, Төрийн өмчийн | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Өмч хувьчлалын 1991-1996 оны нэгдсэн мэдээлэл, судалгааг бүрдүүлэх ажлын хүрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Архивын ерөнхий газарт албан бичиг хүргүүлсэн боловч хариу ирээгүй болно. | “Хэрэгжээгүй” - 0 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бодлого, зохицуулалтын газарт; | | | |
| | 126 | **Хөрөнгө оруулалтын цэнхэр, ягаан тасалбараар хийгдсэн өмч хувьчлалын талаар хийсэн ажлын хэсгийн санал, дүгнэлтийн тухай**<br>2019-12-11, № 54<br>XXIX.1.4. Улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоолоор орон нутгийн өмчид шилжсэн хөрөнгийн өнөөгийн байдал, орон нутгийн өмч хувьчлалын талаарх судалгааг гарган, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулахыг Аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоолоор орон нутгийн өмчид шилжсэн хөрөнгийн өнөөгийн байдал, орон нутгийн өмч хувьчлалын талаарх судалгааг гарган, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хүрээнд Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт чиглэл хүргүүлсэн. | “Хэрэгжилт хангалтгүй” – 30% | |
| 85 | 127 | **ОХУ-ын өмчөөс Монгол Улсын өмчид үнэ төлбөргүй шилжүүлж авсан үл хөдлөх хөрөнгийн тухай**<br>2020-02-12, № 9<br>II. Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газрын хооронд Ноот бичиг солилцох замаар 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан Хэлэлцээрийн хавсралтад заасан Монгол Улсын өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлсэн үл хөдлөх хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч бүртгэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгав; | **ТӨБЗГ- ТӨУЗХ, ТӨБАХ**<br>ОХУ-ын нэр дээрх 14 ширхэг гэрчилгээг хүчингүй болгох хүсэлтийг ТӨБЗГ-ын 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А-1/337 дугаар албан бичгээр УБЕГ-т хүргүүлж, холбогдох баримт, гэрчилгээний эх хувийг хүлээлгэн өгсөн. Монгол Улсын өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлсэн үл хөдлөх хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч бүртгэх асуудлыг шийдвэрлүүлсэн.<br>ТӨБЗГ-ын 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 273 дугаар тогтоолоор ОХУ-ын өмчөөс хүлээж авсан үл хөдлөх хөрөнгийг төрийн өмчид бүртгэх (Дархан-Уул аймаг, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК) тухай шийдвэрийг гаргаж хүргүүлсэн.<br>Монгол Улсад хүлээн авсан барилгын доорх газрын ОХУ-ын нэр дээр байсан эрхийг нийслэлийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/712 дугаар захирамжаар хүчингүй болгосон болно.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 8 болон 18 дугаар тэмдэглэлээр Оросын Холбооны Улсын өмчөөс Монгол Улсын өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан орон сууцны 8 байрны 549 айлын орон сууцыг одоо эзэмшиж буй оршин суугчдад нь үнэ төлбөргүй хувьчлах асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |
| | 128 | **ОХУ-ын өмчөөс Монгол Улсын өмчид** | **ТӨБЗГ- ТӨУЗХ** | “Бүрэн | Бүрэн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **үнэ төлбөргүй шилжүүлж авсан үл хөдлөх хөрөнгийн тухай**<br><br>2020-02-12, № 9<br><br>II.3. Оросын Холбооны Улсын өмчөөс Монгол Улсын өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлж авсан, Хэлэлцээрийн хавсралтад заасан орон сууцны 8 байрыг оршин суугчдад нь хувьчлах бэлтгэл ажлыг хангаж, 2020 оны I улиралд багтаан Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгав. | ТӨБЗГ-ын 2019 оны А/297 дугаар тушаалаар “ОХУ-ын өмчлөлөөс Монгол Улсын өмчлөлд шилжүүлэн авсан орон сууцны 8 байрыг хувьчлах бэлтгэл ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулан ажиллуулав. Ажлын хэсгээс тухайн байруудад амьдарч буй иргэдийн судалгаа гаргах, хувьчлалд бэлтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Зарим байгууллага, иргэдтэй уулзах сонсох ажиллагааг явуулж, орон сууцны асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтэд дурдсан болон бусад мэдээлэл, баримт материалыг хянах, нягтлах, иргэдэд хариу өгөх зэрэг ажлуудыг хийв.<br><br>Ажлын хэсгийн ажлын хүрээнд эдгээр байранд амьдарч буй ОХУ-ын иргэдэд орон сууц хувьчлах эсэх асуудлаар чиглэл хүсэх тухай ТӨБЗГ-ын 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А-1/335 дугаар албан бичгийг ГХЯ, ХЗДХЯ-нд тус тус хүргүүлж, хариу авсан.<br><br>Ажлын хэсгийн ажлын үр дүнд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 8 болон 18 дугаар тэмдэглэлээр Оросын Холбооны Улсын өмчөөс Монгол Улсын өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан орон сууцны 8 байрны 549 айлын орон сууцыг одоо эзэмшиж буй оршин суугчдад нь үнэ төлбөргүй хувьчлах асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлсэн. Засгийн газрын 2020 оны 210, 146 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас холбогдох хууль тогтоомжийн дагуу “Орон сууц эзэмших эрхийн гэрчилгээ”-г тухайн оршин суугчид олгож, харьяалагдах орон нутаг дахь Орон сууц хувьчлах товчоонд “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ” олгуулахаар албан ёсны хүсэлтийг хүргүүлэн ажилласнаар тухайн иргэд уг орон сууцыг хувьдаа өмчлөх эрх зүйн үндэслэл бүхий боломж бүрдсэн. | хэрэгжсэн” – 100% | хэрэгжсэн тул хяналтаас хасуулах саналтай. |
| 86 | 129 | **Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2019 оны жилийн эцсийн дүнгийн тухай**<br><br>2020-03-27, № 21<br><br>III.1. 1.Улсын Их Хурал болон Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрээр Засгийн газар, сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан заалт бүрийг хяналтад авч, хэрэгжүүлэх | **ТӨБЗГ – ЗУХ**<br><br>1. 2020 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт шинээр бүртгэгдсэн Монгол Улсын Засгийн газрын нийт 85 шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангаж, энэхүү тайланд тусган тайлагнаж байна.<br>2. ТӨБЗГ нь үүрэг, даалгавар болгосон шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу тогтоосон хугацаанд “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем” www.unelgee.gov.mn-д байршуулж, холбогдох аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг үнэн зөв, бодитой хийхэд анхааран, гарсан үр дүнг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж хэвшсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Хэвшиж, тогтмолж-сон тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ажлыг шуурхай зохион байгуулах; 2.Үүрэг, даалгавар болгосон шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу тогтоосон хугацаанд "Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим систем" www.unelgee.gov.mn-д байршуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээг үнэн зөв, бодитой хийж, гарсан үр дүнг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсны үндсэн дээр эрх бүхий байгууллагад тайлагнах; 3.2019 оны жилийн эцсийн байдлаар удаашралтай, гүйцэтгэл нь хангалтгүй байгаа үүрэг, даалгаврын шалтгааныг тодорхойлон хэрэгжилтийг эрчимжүүлэх, гүйцэтгэлийг сайжруулах, шаардлагатай бол тухайн шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх; 4.Хэрэгжилт нь тогтмолжсон, бүрэн хэрэгжсэн, нэг удаагийн буюу цаг үеийн шинжтэй шийдвэр, заалтыг хяналтаас хасуулахдаа хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санд зохих тэмдэглэгээ хийж байх; 5. Төрийн эрх бүхий байгууллагууд хамтран баталж, хэрэгжүүлэх эрх зүйн акт (дүрэм, журам, заавар, бусад)-ыг тогтоосон хугацаанд нь батлан мөрдүүлдэг байх; 6. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төсөлд тусгах харилцаа зохицуулалтыг урьдчилан судалж, үр нөлөөг тооцон, санхүү төсвийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн, хэрэгжихүйц байхаар төлөвлөн боловсруулдаг байх; 7. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд салбар, орон нутгийн захиргааны байгууллагуудын уялдаа холбоог сайтар хангаж ажиллах. | 3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2019 оны жилийн эцсийн болон 2020 оны эхний хагас жилийн дүнд дүгнэлт хийж, Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмж, удааширч байгаа шийдвэр, заалтыг нийт албан хаагчдад танилцуулан, хэрэгжилтийг шуурхай хангаж ажиллах талаар Даргын зөвлөлийн 2020 оны 01, 02 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулсан.<br>4. 2019 оны жилийн эцсийн дүнгээр хэрэгжилт нь тогтмолжсон, бүрэн хэрэгжсэн, нэг удаагийн буюу цаг үеийн шинжтэй нийт 31 шийдвэрийн 40 заалтыг хяналтаас хасуулах саналыг тайлангийн хамт ЗГХЭГ-т хүргүүлж, хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн санд зохих тэмдэглэгээ хийсний үндсэн дээр хяналтаас хасуулсан. Харин 2020 оны жилийн эцсийн энэхүү тайлангийн дүнгээр нийт 60 шийдвэрийн 84 заалтыг хяналтаас хасуулах саналыг ЗГХЭГ-т тавьж шийдвэрлүүлэхээр бэлтгэв. | | |
| | 130 | **Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн** | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн | "Хэрэгжилтийг | Ач холбогдол- |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **хэрэгжилтийн 2019 оны жилийн эцсийн дүнгийн тухай**<br>2020-03-27, № 21<br>III.3. 2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, холбогдох Засгийн газрын агентлагийн дарга нарт үүрэг болгов:<br>2.1.үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой зааж байх; 2.2.үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тухайн жилийн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлэх. | чиглэлд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хариуцан хэрэгжүүлж тайлагнах арга хэмжээ тусгагдаагүй болно. | тооцох хугацаа болоогүй” – ХБ. | гүй болсон, холбогдох хууль, эрх зүй баримт бичиг өөрчлөгд-сөн, 2020 оны үндсэн чиглэлд заалт тусгагдаа-гүй тул хяналтаас хасах саналтай. |
| 87 | 131 | **Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай тайлан, үнэлгээний дүнгийн тухай**<br>2020-04-01, № 22<br>XYIII.2. 2. Дараахь арга хэмжээ авахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав: 2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллах; 2.2. Худалдан авах ажиллагааны тайланг цахим системд нийтэлж, бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр бүрээр бүрэн тайлагнах; 2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Агентлаг байгуулах тухай” 438 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүрэг өөрчлөгдөж, Ерөнхий сайдын 2020 оны 06 дугаар захирамжаар байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдэн батлагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны чиг үүрэг шинээр байгуулагдсан агентлагт шилжсэн.<br>2020 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь өөрийн байгууллагын хэрэгцээнд шаардлагатай барааны 3 худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан бөгөөд 2 нь нээлттэй сонгон шалгаруулалтын журмаар, уламжлалт аргаар, 1 нь шууд худалдан авалт байна. 2020 оны төсвийн жилд зохион байгуулагдсан худалдан авах ажиллагааны холбогдох төлөвлөгөө, зар мэдээлэл, тайланг ил тод, нээлттэй мэдээлэх арга хэмжээ авсан. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | Хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчлийг арилгаж, гэрээнд заасан хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаж, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг тус хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтын хамт тухай бүр Сангийн яаманд хүргүүлэх; 2.4. Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа захиалагч бусдад давуу байдал олгох, бодит шаардлагаас хэтрүүлэн өндөр эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээний эцсийн үр дүн, гүйцэтгэлд шууд хамаарахгүй шалгуур үзүүлэлтийг тавихгүй байх, тендерийн шалгуур үзүүлэлтийг чанар, эцсийн үр дүнд үндэслэн боловсруулах. | | | |
| 88 | 132 | **2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр 26 дүгээр тэмдэглэл**<br>2020-04-22, № 26<br>YII. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгох;<br>2. Дулааны тоолуур худалдан авах, суурилуулахад шаардагдах хөрөнгийг төсөвт байгууллагын зарлагын хэмнэлт, давсан орлогоос холбогдох хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлэхийг Төсвийн захирагч нарт зөвшөөрөх; | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Коронавируст цар тахлын нөхцөл байдлын үед улс орны хэмжээнд авах арга хэмжээний хүрээнд төсвийн байгууллагуудад хэрэгжих хөрөнгө оруулалт болон нэг удаагийн шинжтэй арга хэмжээ, бүх төрлийн сургалт семинар, урлаг, спортын арга хэмжээ, гадаад, дотоод томилолт, урсгал болон их засвар, тавилга, тоног төхөөрөмж худалдан авах гэх мэт тэвчиж болох зардлын санхүүжилтийг Сангийн яамнаас хязгаарласан байгаа тул хэрэгжилт хангагдаагүй байна. Хэрэгжих хугацаа болоогүй. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| 89 | 133 | **2020 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр 28 дүгээр тэмдэглэл**<br>2020-04-29, № 28<br>IX.3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрийн албанаас өндөр насны | **ТӨБЗГ – ЗУХ**<br>2020 онд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг эрх нь үүссэн төрийн захиргааны 5, төрийн үйлчилгээний 2 албан хаагчид, төрийн захиргааны 4 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг шинээр болон нэмэгдүүлэн тус тус олгосон. Байгууллагын 4 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарсан бөгөөд шаардлагатай хөрөнгийг 2020 оны | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоол гарсан, цаашид |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, цаашид жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгах. | төсөвт суулгасны үндсэн дээр тэдгээр албан хаагчдад нийт 92,104.1 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгосон байна.<br>Цаашид тус тогтоолд заасны дагуу хүний нөөцийн судалгаа, тооцоонд үндэслэн шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | | энэ тогтоол, тэмдэглэл хэрэгжих боломжтой тул хяналтаас хасах саналтай. |
| 90 | 134 | **2020 оны 5 дугаар сарын 20-ны өдөр 32 дүгээр тэмдэглэл**<br>2020-05-20, № 32<br>Х. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас нөхцөл байдал хүндрээд буй Оросын Холбооны Улсад 1.0 (нэг) сая ам.доллартай тэнцэх хэмжээний хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, үүнд мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх нь зүйтэй гэж үзэв. 2. Уг тусламжид шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас гаргуулах арга хэмжээ авч, зохих журмын дагуу шийдвэрлүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т даалгах. | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Засгийн газрын энэхүү тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит 9 дүгээр хуралдаанаар Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас нөхцөл байдал хүндрээд буй Оросын Холбооны Улсад 1.0 (нэг) сая ам.доллартай тэнцэх хэмжээний хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, үүнд мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэхэд шаардагдах хөрөнгийг зохих эх үүсвэрээс гаргахыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын захирал Х.Бадамсүрэнд зөвшөөрч, уг асуудлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 317 дугаар тогтоолыг гарган шийдвэрлэсэн. | “Бүрэн хэрэгжсэн”-100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 91 | 135 | **2020 оны 7 дугаар сарын 29-ний өдөр 42 дугаар тэмдэглэл**<br>2020-07-29, № 42<br>Ү.1. Соёлын яамыг байршуулах байрны талаар Соёлын сайд С.Чулуун Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Соёлын яамыг нийслэлийн Сүхбаатар дүүргийн 7 дугаар хороонд байрлах “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын эзэмшлийн 15 дугаар байранд түр байршуулах талаар шаардлагатай арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Соёлын сайд С.Чулуун, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын | **ТӨБЗГ – ТӨБАХ**<br>Соёлын яамыг “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ-ын эзэмшилд байгаа хуучнаар Лаосын элчин сайдын яам байрлаж байсан байранд байршуулж, төрийн өмчийн түрээсийн гэрээ байгуулсан. | “Бүрэн хэрэгжсэн”-100% | Хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | газар (Б.Цэнгэл) нарт даалгав. | | | |
| 92 | 136 | **2020 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр 48 дугаар тэмдэглэл**<br>2020-09-09, № 48<br>XI.1. 2. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын үлдэгдэл хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэх санал боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ**<br>Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын үлдэгдэл хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэх асуудлыг Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын 117 дугаар тогтоолоор “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн хувьцааг хаалттай хүрээнд нэрлэсэн үнээр худалдах замаар нийт хувьцааны 66 хувийг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-д, 34 хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д тус тус эзэмшүүлэх, цаашид “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг “Монголын төмөр зам” ТӨХК-д эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу үе шаттай шийдвэрлүүлэх үүргийг холбогдох яам, удирдлагуудад өгсөн.<br>2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр болсон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “Эрдэнэс-Тавантолгой” ХК, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүдийг үндэслэн “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийг үүсгэн байгуулах тогтоолыг баталж, компанийг байгуулан үйл ажиллагааг эхлүүлээд байна. “Зүүнбаян төмөр зам” ХХК нь 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн бөгөөд “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн гүйцэтгэх захирлаар Д.Банзрагчийг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс томилсон. Одоогийн байдлаар “Зүүнбаян төмөр зам” ХХК нь 18 үндсэн ажилтантайгаар үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | Засгийн газрын 2020 оны 117 дугаар тогтоол гарсан тул энэ тэмдэглэ-лийг цаашид хяналтаас хасах саналтай. |
| | 137 | **2020 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр 48 дугаар тэмдэглэл**<br>2020-09-09, № 48<br>XI.1. 4. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2016-2020 оны хөрөнгө оруулалт, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨХШХ**<br>Тэмдэглэлээр өгсөн үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сангийн сайдын 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын холбогдох 3 мэргэжилтэн удирдамжийн дагуу ажиллаж байна. Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө баталсан бөгөөд “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 2016-2020 оны хөрөнгө оруулалт, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт болон тус компаниас “Тавантолгой төмөр зам” ХХК, “Тавантолгой түлш” ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт, түүний зарцуулалтад хяналт шалгалт хийж байна. | “Хэрэгжих шатанд” – 70 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Хяналт шалгалтын ажил 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс эхэлсэн бөгөөд Монгол Улсад шинэ коронавирусын халдавр бүртгэгдэж, бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин, хатуу хөл хорионы дэглэм тогтоож ажилласны улмаас хяналт шалгалтын ажлын хугацааг Сангийн сайдын тушаалаар 1 сарын хугацаагаар сунгаж, 2021 оны 1 дүгээр сард дуусган дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар ажиллаж байна. | | |
| 93 | 138 | **2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр 52 дугаар тэмдэглэл**<br>2020-09-30, № 52<br>XYII.4.8. “АСА Консалтинг” ХХК-тай циркийн урлагийн мэргэжлийн удирдлага, үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүйгээр, зориулалтын дагуу ажиллуулах нөхцөлтэйгээр байгуулсан холбогдох гэрээний хэрэгжилтийг хангуулах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Соёлын сайд С.Чулуун, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт. | **ТӨБЗГ – ТӨУЗХ, ТӨБАХ**<br>Шудрага өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газарт Циркийн хувьчлалтай холбоотой холбогдох материал, судалгааг Архивийн ерөнхий газраас авч хүргүүлсэн. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | | **Тэмдэглэл: 16 шийдвэрийн 24 заалт** | **100%-11 заалт; 70%-2 заалт; 30%-1 заалт; 0% - 3 заалт; ХБ/ҮБ – 7 заалт; Хэрэгжилтийн хувь – 74.7%** | | **Хасах санал: 16** |
| **Ес. Засгийн газрын албан даалгавар** | | | | | |
| 94 | 139 | **Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай**<br>2019-10-16, № 03<br>1.1.Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний төлбөр тооцоонд "Цахим төлбөрийн баримтын систем" (ebarimt) нэвтрүүлэх ажлыг 2019 онд багтаан иргэдэд чирэгдэл үүсгэлгүйгээр шуурхай зохион байгуулах. | **ТӨБЗГ – Бүх хэлтэс, алба**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт цахим төлбөр тооцоонд шилжүүлэх үйлчилгээ одоогоор байхгүй болно. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | 140 | **Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай** | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Одоогоор ТӨБЗГ-ын хуулиар хүлээсэн чиг үүргийн хувьд цахим төлбөр тооцоонд шилжүүлэх үйлчилгээ байхгүй болно. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2019-10-16, № 03<br>1.2. Цахим төлбөр тооцоонд шилжихтэй холбоотойгоор үйлчилгээний ажилтнуудыг сургаж бэлтгэх, төлбөр тооцооны системийн талаар иргэдэд сурталчлан таниулах. | | ХБ. | |
| | 141 | **Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай**<br>2019-10-16, № 03<br>1.3. Цахим гарын үсгийн хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх. | **ТӨБЗГ – Бүх хэлтэс, алба**<br>Одоогоор ТӨБЗГ-ын хуулиар хүлээсэн чиг үүргийн хувьд цахим төлбөр тооцоонд шилжүүлэх үйлчилгээ байхгүй болно. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | 142 | **Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай**<br>2019-10-16, № 03<br>1.4. Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах. | **ТӨБЗГ – Бүх хэлтэс, алба**<br>Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөр авах үйлчилгээ байхгүй. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | 143 | **Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай**<br>2019-10-16, № 03<br>1.5. Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэхтэй холбогдуулан шаардлагатай бол эрхлэх асуудлын хүрээнд болон нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөж байгаа эрх зүйн актуудад зохих өөрчлөлт оруулах. | **ТӨБЗГ – ХЭЗХ, Бүх хэлтэс, алба**<br>Одоогоор ТӨБЗГ-ын хуулиар хүлээсэн чиг үүргийн хувьд цахим төлбөр тооцоонд шилжүүлэх үйлчилгээ байхгүй болно. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | 144 | **Төрийн үйлчилгээнд цахим төлбөр тооцоог нэвтрүүлэх тухай**<br>2019-10-16, № 03<br>3. Албан даалгаврын хэрэгжилтийг дүгнэж, тайланг улирал бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, албан даалгаврын хэрэгжилтэд | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Одоогоор ТӨБЗГ-ыг хуулиар хүлээсэн чиг үүргийн хувьд цахим төлбөр тооцоонд шилжүүлэх үйлчилгээ байхгүй тул албан даалгаврын хэрэгжилтийг тусгайлан тайлагнаагүй. 2019 оны жилийн эцэст болон 2020 оны хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хагас, бүтэн жилийн тайланд тусган мэдээлсэн болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хяналт тавьж, үр дүнг улирал тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд. | | | |
| 95 | 145 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19, № 2<br>1. Дор дурьдсан арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 1.1. Салбар болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх цахим шилжилтийн арга хэмжээний төслийг хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх; | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолыг үндэслэн Ерөнхий сайдын 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 79 дүгээр захирамжаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц”-ийг шинэчлэн баталсантай холбоотойгоор салбарын цахим шилжилтийн арга хэмжээний бодлого, төсөл, арга хэмжээг хариуцан ажиллах Мэдээлэл, технологийн албыг шинээр байгуулсан. Цаашид энэ албан даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр 2021 оны төлөвлөгөөнд тусган ажиллахаар төлөвлөөд байна. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | 146 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19, № 2<br>1.2. Цахим хэлбэрээр үзүүлж буй үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд нэгтгэх болон цаашид иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөг үйлчилгээний жагсаалтын хамт боловсруулан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлэх; | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолыг үндэслэн Ерөнхий сайдын 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 79 дүгээр захирамжаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц”-ийг шинэчлэн баталсантай холбоотойгоор салбарын цахим шилжилтийн арга хэмжээний бодлого, төсөл, арга хэмжээг хариуцан ажиллах Мэдээлэл, технологийн албыг шинээр байгуулсан. Цаашид энэ албан даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр 2021 оны төлөвлөгөөнд тусган ажиллахаар төлөвлөөд байна. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | 147 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19, № 2<br>1.3. Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэх; | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолыг үндэслэн Ерөнхий сайдын 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 79 дүгээр захирамжаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц”-ийг шинэчлэн баталсантай холбоотойгоор салбарын цахим шилжилтийн арга хэмжээний бодлого, төсөл, арга хэмжээг хариуцан ажиллах Мэдээлэл, технологийн албыг шинээр байгуулсан. Цаашид энэ албан даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр 2021 оны төлөвлөгөөнд | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тусган ажиллахаар төлөвлөөд байна. | | |
| | 148 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19, № 2<br>1.4. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч буй аливаа лавлагаа тодорхойлолтыг шалган баталгаажуулж байх, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, харилцан солилцож байх; | **ТӨБЗГ – ЗУХ, ТӨБАХ**<br>Одоогоор төрийн үйлчилгээний нэгдсэн системээс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуулиар тогтоосон чиг үүргийн дагуу гарган үйлчлэх үйлчилгээ тусгагдаагүй байна. Харин бусад байгууллагын үйлчилгээтэй холбоотой аливаа лавлагаа, тодорхойлолтыг өөрийн үйл ажиллагаанд ашиглаж, иргэдэд үйлчлэх үйлчилгээг шуурхай хүргэх боломжийг судалж байна. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | 149 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19, № 2<br>1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах; | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх талаар судлан, 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахаар төлөвлөж байна. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | 150 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19, № 2<br>1.6. Төрийн цахим үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах; | **ТӨБЗГ – ЗУХ**<br>Одоогоор тус байгууллагаас цахим үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ байхгүй, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээнд холбох үйлчилгээ үгүй тул төлбөр тооцооны асуудал гараагүй байна. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | 151 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19, № 2<br>1.7. ХУР системд холбогдсон мэдээллийн системийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай нягт хамтран ажиллах; | **ТӨБЗГ – ЗУХ**<br>ХУР системд холбогдсон мэдээлэл байхгүй. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | 152 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br>2020-11-19, № 2 | **ТӨБЗГ – ЗУХ**<br>ХУР систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” цонхонд нэгтгэх төрийн үйлчилгээ байхгүй. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1.8. Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах; | Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолыг үндэслэн Ерөнхий сайдын 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 79 дүгээр захирамжаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц”-ийг шинэчлэн баталсантай холбоотойгоор салбарын цахим шилжилтийн арга хэмжээний бодлого, төсөл, арга хэмжээг хариуцан ажиллах Мэдээлэл, технологийн албыг шинээр байгуулсан. Уг албаны хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах, мэдээллийн технологийн асуудал хамаарч байгаа болно.<br><br>Цаашид энэ албан даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр 2021 оны төлөвлөгөөнд тусган ажиллахаар төлөвлөөд байна. | | |
| | 153 | **Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай**<br><br>2020-11-19, № 2<br><br>1.9. Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг “Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем”-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох. | **ТӨБЗГ – ЗУХ**<br><br>Байгууллагын дотоод үйл ажиллагаанд удирдлагын мэдээллийн цогц систем “Able”-ийг ашиглаж, цаг бүртгэлийн төхөөрөмжийг холбож, албан хэрэг хөтлөлтийн бүртгэлийг хөтлөн дотоод мэдээлэл солилцоог ханган, албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.<br><br>Цаашид байгууллага хооронд албан бичгийг цахим хэлбэрээр солилцох шийдлийг бий болгон нэгдсэн системд холбогдох асуудлыг судалж байна.<br><br>Энэ талаар ажиллах чиг үүрэг бүхий нэгжийг байгууллагын зохион байгуулалтын бүтцэд бий болгон ажиллуулж эхлээд байгаа нь цахим шилжилтийн асуудалд анхаарал хандуулах, тодорхой ахиц өөрчлөлт гаргах боломжийг бүрдүүлээд байна. | “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” – ХБ. | |
| | | **Албан даалгавар: 2 шийдвэрийн 15 заалт.** | **100% - 1 заалт; ХБ/ҮБ – 15; Хэрэгжилтийн хувь - 100.0%.** | | **Хасах санал: 0** |

**(Нийт 9 төрлийн 95 шийдвэрийн 153 заалтын хэрэгжилтийг тайлагнав)**

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН (нэр төрлөөр)
(2020 оны жилийн эцсийн дүн)

| Д/д | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр төрөл | Шийдвэрийн тоо | Хэрэгжилтийг тооцсон заалтын тоо | Үүнээс: | | | | | Хэрэгжилтийн явц (хувиар) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бүрэн хэрэгжсэн (100 %) | Хэрэгжих шатанд (70 %) | Хэрэгжилт хангалтгүй (30 %) | Хэрэгжээгүй (0 %) | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй (ХБ.) | |
| 1 | Монгол Улсын хууль | 2 | **2** | 2 | | | | | **100.0** |
| 2 | УИХ-ын тогтоол | 6 | **11** | 10 | | | | 1 | **100.0** |
| 3 | УИХ-ын Байнгын хорооны тогтоол | 5 | **7** | 3 | 2 | | | 2 | **88.0** |
| 4 | Ерөнхийлөгчийн зарлиг | 1 | **1** | | | | | 1 | **-** |
| 5 | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж | 2 | **2** | 2 | | | | | **100.0** |
| 6 | Засгийн газрын тогтоол | 59 | **89** | 62 | 15 | 1 | 1 | 10 | **92.2** |
| 7 | Ерөнхий сайдын захирамж | 2 | **2** | | 1 | | | 1 | **70.0** |
| 8 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 16 | **24** | 11 | 2 | 1 | 3 | 7 | **74.7** |
| 9 | Засгийн газрын албан даалгавар | 2 | **15** | 1 | | | | 14 | **100.0** |
| **Хэрэгжилтийн дүн (шийдвэр, заалтын тоо)** | | **95** | **153** | **91** | **20** | **2** | **4** | **36** | **90.26** |

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Н.ГАНБОЛД

Нэгтгэн боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ